



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ




Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • IX • № 37

**Н.БАЯРТСАЙХАН:
МӨНГӨНИЙ БОДЛОГО,
БАНКНЫ ХЯНАЛТ
ЗОХИЦУУЛАЛТ НЬ
ДУНД ХУГАЦААНЫ
ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ДАРХЛААГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД
ЧИГЛЭНЭ**

**ҮНИЙН
ТАЛААРХ
ҮНДСЭН
ОЙЛГОЛТУУД**



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН
САНГААС: ЦАГААН ДАРА ЭХ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ ТУХАЙ

Дугаар: 2019/03

Огноо: 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хадгалах шийдвэр гаргалаа.

Жилийн инфляци 2019 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.9 хувь байна. Мах, хүнсний ногоо, их дээд сургуулиудын сургалтын төлбөр болон бусад төрийн зохицуулалттай бүтээгдэхүүний үнэ сүүлийн саруудад өсч, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг нэмэгдүүллээ. Эрэлтийн шалтгаантай суурь инфляци харьцангуй тогтвортой байна. Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс, эдийн засгийн идэвхжлийг харгалзан үзэхэд инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих төлөв хадгалагдаж байна.

Энэ оны эхний хагас жилд уул уурхайн олборлолтын хэмжээ хүлээлтээс давж, бизнесийн зээл, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, төсвийн зардал нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт өндөр түвшинд хадгалагдлаа.

Өмнөх улиралтай харьцуулахад том гүрнүүдийн худалдааны сөргөлдөөн улам гүнзгийрч, гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэн, цаашид гадаад эрэлт, түүхий эдийн үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжин дотоод эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд дотоод, гадаад тэнцвэрийг хадгалахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, бүх секторын түвшинд санхүүгийн нөөцийг хуримтлуулж, эрсдэл даах чадварыг бэхжүүлэх шаардлага өндөр байна.

Эдийн засгийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг өөрчлөхгүй байхаар шийдвэрлэв. Уг шийдвэр нь инфляцийг зорилтот түвшний орчимд тогтворжуулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн болон санхүүгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалах зорилттой нийцтэй болно.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Зүүн болон Говийн бүсийн банкны салбарын удирдах ажилтны зөвлөгөөн боллоо

4

Ярилцлага:

ХУУДАС

Н.Баяртсайхан: Мөнгөний бодлого, банкны хяналт зохицуулалт нь дунд хугацааны тогтвортой байдлын дархлааг нэмэгдүүлэхэд чиглэнэ

7

Инфографик:

ХУУДАС

Төрөөс Мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

10

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас ... (2019.09.17)

12

Нийтлэл:

ХУУДАС

Үнийн талаарх үндсэн ойлголтууд

16

Байр суурь:

ХУУДАС

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг хэрхэн зохицуулах вэ?

18

Монголбанк юу хийдэг вэ?

ХУУДАС

Д.Баянзул: Төв банкны нэр хүндэд зориудаар халдах үйлдэл нь нийтээрээ үүрэх эрсдэлд хүргэдэг

22

Монголбанкны мэдээлэл:

ХУУДАС

Монголбанк 11.2 тонн алт худалдан авлаа

25

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Худалдааны дайн ба ам.долларын ханшийн төлөв

27

Банкир:

ХУУДАС

Б.Даваадалай: Төв банк нийлүүлэлтийн гаралтай инфляцид шууд хариу үйлдэл үзүүлэх нь зохисгүй

31

Мөнгөн тэмдэгтийн түүх:

ХУУДАС

Аргун хааны мөнгөн зоос

34

Судалгаа, шинжилгээ:

ХУУДАС

Эдийн засгийн сэргэлт, түүний өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөө


35

Зүүн болон говийн бүсийн банкны салбарын удирдах ажилтны зөвлөгөөн боллоо

Монголбанкнаас санаачлан гурав дахь жилдээ зохион байгуулж буй Банкны ажилтны удирдах ажилтаны зөвлөгөөнийг Дорноговь аймгийн Сайншанд хотод энэ сарын 5-6-ны өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Монголбанкны төв болон орон нутаг дахь салбар, хэлтэс, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан болон ХХБ, ХААН, Голомт, Хас, Төрийн банк зэрэг байгууллагууд оролцов. Энэ удаагийн Зүүн болон Говийн бүсийн банкны удирдах ажилтны зөвлөгөөнд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан оролцож, зөвлөгөөнийг нээж хэлсэн үгэндээ мөнгөний бодлогын хэрэгжилтэд банкуудын үүрэг оролцоо өндөр болохыг цохон тэмдэглэхийн хамт, улсын эдийн засгийн өсөлтийг хадгалах, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх төдийгүй, улсын гадаад өр төлбөрийг барагдуулах хугацаа ойртож буй амаргүй жилүүдийн сорилтыг даван туулахад бэлтгэлтэй байхыг тодотголоо.



Монголбанк үйл ажиллагааны шинэчлэлийн хөтөлбөрөө танилцуулав



Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-10 дугаар тушаалаар “Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр 2017-2019”-ийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн үндсэн 5 чиглэлийн шинэчлэлийн дагуу Монголбанк өнгөрсөн хугацаанд хийж, хэрэгжүүлсэн ажлуудаа танилцууллаа. Тухайлбал, хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль зэрэг банкны салбарын суурь болсон томоохон хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх хүрээнд мөнгөний бодлогын шийдвэрийг хамтын удирдлагын зарчим буюу Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэн шийдвэрлэх тогтолцоог нэвтрүүлсэн, бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх чиг үүргийг салгах зарчмыг баримтлан хэрэгжүүлж эхэлсэн, Хүний нөөцийн чадавхийг сайжруулах хүрээнд олон улсын туршлагад суурилсан, Төв банкны Үндсэн зорилтод нийцтэй “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн боловруулж, үйл ажиллагаанд мөрдөж эхэлсэн зэрэг онцлох ажлуудаа олон нийтэд таницуулав.

Дэлхийн банкны Дэд Ерөнхийлөгч Жинг Дон Хуа бусад албаны хүмүүсийн хамт Монголбанкнд зочлов

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдлагууд хамт Дэлхийн банкны Дэд Ерөнхийлөгч Жинг-Дон Хуа, ОУСК-ийн Дэд Ерөнхийлөгч Нена Стойлкович болон тэднийг дагалдах төлөөлөгчдийн хамт хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр талууд Монголбанк болон Дэлхийн банкны хамтын ажиллагаа, Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, Нөөцийн удирдлагын “РАМП” хөтөлбөр, Монгол Улс ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн явцын талаар мэдээлэл солилцов. Тус хөтөлбөрийн талаар Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Монголбанкнаас Засгийн газартай хамтран ОУВС-аас хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төсвийн сахилга бат сайжирч, мөнгөний бодлогын үр нөлөө зорилтоо биелүүлж, эдийн засагт сэргэлт бий болсон нааштай үр дүнд хүрч буйг танилцуулаад, хөтөлбөрийг үргэлжлүүлэх шаардлагатай буйг онцолж, энэ талаар болон бусад холбогдох асуудлаар санал солилцлоо.



“Төлбөрийн тэнцэл ба гадаад өр” сэдэвт онол практикийн бага хурал болов



Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан Монголбанкны санаачилгаар “Төлбөрийн тэнцэл ба гадаад өр” сэдэвт онол практикийн бага хурлыг 2019 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Уг онол практикийн бага хуралд санхүү, эдийн засгийн судлаач, шинжээчид оролцож, Монгол Улсын эдийн засгийн гадаад тэнцвэр, өрсөлдөх чадварыг сайжруулах, валютын орлогыг нэмэгдүүлэх боломж, бодлогын алхмууд мөн гадаад өрийн удирдлагад баримтлах стратеги гэсэн үндсэн асуудлуудаар судалгаа, шинжилгээний ажлынхаа үр дүнг хэлэлцэж, байр сууриа илэрхийллээ. Уг асуудлууд нь гадаад зах зээлийн тогтворгүй байдал, гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд чухал ач холбогдолтой юм. Хуралд Монголбанк, ОУВС, Дэлхийн банк, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчдын яам, арилжааны банкууд, эдийн засгийн судалгааны байгууллагууд, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн 80 гаруй төлөөлөгч оролцов.

НҮБ-ын бүсийн хурал манай улсад боллоо

Нэгдсэн Үндсэний Байгууллага (НҮБ)-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх сэдэвт бүсийн хурал 2019 оны 9 дүгээр сарын 17-ноос 19-нд Улаанбаатар хотноо боллоо. Тус хуралд Балба, Бангладеш, Малайз, Мальдив, Филиппин, Шри-Ланка Улсаас тус бүр 5 төлөөлөгч мөн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн албаны Терроризмоос урьдчилан сэргийлэх хэлтэс, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зөвлөл, НҮБ-ын Терроризмтэй тэмцэх алба, АНУ-ын Миддлбери Институт зэрэг байгууллагын холбогдох албан тушаалтнууд уригдан оролцов. Хурлаар НҮБ-ын терроризмын санхүүжүүлэлт болон үй олноор хөнөөх зэвсэгтэй тэмцэх тогтолцоо, холбогдох олон улсын стандарт, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан Исламын улсын эсрэг хориг арга хэмжээний тогтоолууд, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх үйл ажиллагааны санхүүжилттэй тэмцэх тогтолцоо болон холбогдох хөрөнгийн царцаалт зэрэг сэдвээр илтгэл тавигдлаа.



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл хуралдав




Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2019 оны III улирлын ээлжит хуралдаан 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдлаа. Тус хуралдаанаар (i) Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, (ii) Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийг даатгалд хамруулах тухай зэрэг асуудлуудыг СТБЗ-ийн гишүүдэд танилцуулж хэлэлцүүлээ. СТБЗ-ийн ээлжит хуралдааныг Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Х.Бум-Эрдэнэ даргалж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн болон бусад холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн 2 дугаар хуралдаан боллоо

Төлбөрийн системд оролцогч байгууллагуудаас бүрдсэн Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн 2 дугаар хуралдаан өнөөдөр боллоо. Ээлжит хуралдаанаар төлбөрийн системд нэвтрүүлээд удаагүй байгаа АСН+ системд шууд болон шууд бус оролцогч хэн байх, дансны нэгдсэн сангийн тухай оролцогч байгууллагуудад тайлбарлалаа. Мөн төлбөрийн системийн нэгдсэн журмын төслийг танилцуулж, үндэсний төлбөрийн системд банкуудын гүйцэтгэж буй үүрэг, шийдвэрлэх асуудлуудыг хэлэлцүүлсэн юм. Төлбөрийн системийн тухай хуулиар Төлбөр тооцооны үндэсний зөвлөл гэж байсныг Үндэсний төлбөрийн системийн зөвлөл болгож Монголбанкны харьяанд байхаар заасан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн А-261 тушаалаар баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулах юм.



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах Үндсэн чиглэлийн төслийг өргөн барилаа



Төрийн мөнгөний бодлого нь Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгоход чиглэсэн бодлогын зорилтуудыг тусгалаа.

Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт өнгөрсөн жилүүдэд тулгарсан олон хүнд сорилтын дийлэнхийг амжилттай шийдвэрлэсний үр дүнд эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдал, ойрын ирээдүйн төлөв сайжирч байна. Тухайлбал, макро эдийн засгийн нөхцөл байдал 2017 оноос тогтворжиж, 2018, 2019 онд сэргэлт үргэлжиллээ. Энэ нь төсөв болон мөнгөний бодлогууд дээр хийгдсэн оновчтой тохиргоо, банкны салбарт хийсэн цогц реформ, гадаад эдийн засгийн орчны харьцангуй таатай байдал, олон улсын санхүүгийн байгууллагууд болон 2 талт хамтын ажиллагаат орнуудын дэмжлэг туслалцааны үр дүн байв.

Хятад-Монголын дугуй ширээний уулзалтыг Шанхай хотноо зохион байгууллаа

Хятад-Монголын банк, санхүүгийн хамтын ажиллагааны 8 дахь удаагийн дугуй ширээний уулзалтыг БНХАУ-ын Шанхай хотноо 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Уулзалтад Монголбанк, Хятадын Ардын банк болон хоёр улсын банк, санхүүгийн байгууллагын төлөөллүүд оролцлоо.

Уулзалтаар БНХАУ, Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, худалдаа, банк, санхүүгийн салбар дахь хамтын ажиллагаа, хоёр улсын үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн явц болон “Бүс ба зам” санаачилга зэрэг сэдвийн хүрээнд өргөн агуулга дор харилцан санал солилцлоо. Үүнээс гадна эдүгээ хоёр улсын банк, санхүүгийн байгууллага хооронд үүсэж буй хүндрэл, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр тохиролцоонд хүрлээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан, УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барилаа.



Н.БАЯРТСАЙХАН: МӨНГӨНИЙ БОДЛОГО, БАНКНЫ ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТ НЬ ДУНД ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ДАРХЛААГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭНЭ



Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ирэх жил төрөөс баримтлах мөнгөний бодлогын зорилтын талаар ярилцлаа.

1. Монгол Улсын мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, Төв банкны удирдсан өнгөрсөн гурван жилийн бодлогын үр дүнг тоогоор хэмжвэл ямар үзүүлэлт гарах бол?

Нааштай эерэг өөрчлөлт олон гарлаа. Мэдээж хэрэг дан ганц Монголбанкны бодлого үйл ажиллагаанаас гадна олон хүчин зүйлс нөлөөлснийг онцлох нь зүйтэй. Монгол Улсын эдийн

засаг, банк, санхүүгийн салбарт өнгөрсөн жилүүдэд тулгарсан олон хүнд сорилтын дийлэнхийг амжилттай шийдвэрлэсний үр дүнд эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдал бэхжиж байна. Макро эдийн засгийн нөхцөл байдал 2017 оноос тогтворжиж, 2018, 2019 онд сэргэлт үргэлжилж байгааг энэ тойм хүснэгтээс харж болно. Тухайлбал, эдийн засаг энэ оны эхний хагаст 7.3 хувиар өссөн, инфляци зорилтот түвшинд

тогтворжиж, ГВАН 3.7 тэрбум ам.долларт (8 сарын импортын хэрэгцээг хангах хэмжээнд) хүрсэн, улсын төсөв 2018 он болон 2019 оны эхний 8 сард ашигтай гарч, Засгийн газрын өрийн ДНБ-ий харьцаа буурсан, зээлийн хүү 2016 оноос 3.0-3.5 нэгж хувиар буурсан, ажил эрхлэлт нэмэгдсэн, Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулсан зэрэг олон эерэг өөрчлөлтийг дурдахаар байна.

	Уналтын доод үе	Сэргэлтийн үед
Инфляци	↘ Дефляци (2016Q3-Q4)	↗ Инфляци 7.7% (2019Q2)
ДНБ-ийн өсөлт	↘ -1.4% (2016Q3, 4 улирал); -6.0% (2016Q3)	↗ +6.9% (2018); +8.6% (2019Q1)
Ажилгүйдлийн түвшин	↗ 11.6% (2016Q1)	↘ 6.6% (2018Q4)
Өрхийн бодит орлого	↘ 2014Q1-2016Q4 хооронд дараалсан 12Q	↗ 2017Q1-ээс өссөн; 7.4% (2018Q4)
Хувийн хэрэглээ	↘ 2016Q2-2016Q3	↗ 7.1% (2018Q4)
Хөрөнгө оруулалт	↘ Дунджаар -18.3% (2013Q1-2015Q4)	↗ 28.2% (2018)
Төлбөрийн тэнцэл	↘ -\$2.6 тэрбум (2013-2016)	↗ +\$1.8 тэрбум (2017-2019.06)
Валютын нийт нөөц	↘ \$1 тэрбум	↗ \$4.0 тэрбум (2019.06)
Зээлжих зэрэглэл	↘ Унасан (2014-2016)	↗ Сайжирсан (2018-2019)
Зээлийн өсөлт	↘ -5% (2015.07-2016.05)	↗ +24% (2018)
Зээлийн хүү (ЖДХ)	↗ 20% +	↘ 16.9% (2018.12)
Төсвийн тэнцэл	↘ -₮1.4 их наяд (2011-2017оны дундаж)	↗ +540 тэрбум (2019 оны эхний 7 сарын байдлаар)



**Нааштай эерэг
өөрчлөлт олон гарлаа.
Мэдээж хэрэг дан
ганц Монголбанкны
бодлого үйл
ажиллагаанаас гадна
олон хүчин зүйлс
нөлөөлснийг онцлох
нь зүйтэй. Монгол
Улсын эдийн засаг,
банк, санхүүгийн
салбарт өнгөрсөн
жилүүдэд тулгарсан
олон хүнд сорилтын
дийлэнхийг амжилттай
шийдвэрлэсний үр
дүнд эдийн засгийн
болон санхүүгийн
тогтвортой байдал
бэхжиж байна.**



2. Эдийн засгийн сэргэлтэд нөлөөлсөн гол хүчин зүйлс юу вэ?

Сэргэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс гэвэл нэгдүгээрт, экспортын үнэ, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад эрэлт зэргээр тодорхойлогдох гадаад таатай орчин; хоёрдугаарт, төсөв, мөнгөний бодлого, санхүүгийн зохицуулалт; гуравдугаарт, ОУВС-ийн хөтөлбөр, түүнийг дэмжиж буй олон улсын санхүүгийн байгууллагууд, донор улсуудын дэмжлэг; дөрөвдүгээрт, бодлого боловсруулагч төрийн байгууллагуудын гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад чиглэсэн нээлттэй харилцаа зэргийг дурдмаар байна. Эдгээрээс Монголбанкны хувьд мөнгөний бодлого, банкны зохицуулалтын арга хэмжээг тодруулъя. Эдийн засгийн уналтыг тогтворжуулснаар сэргэлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг 2017, 2018 онд шат дараатай бууруулсны зэрэгцээ хэрэглээний зээлээс илүүтэйгээр ажлын байр бий болгох бизнесийн зээлийг нэмэгдүүлэх арга хэмжээний үр дүнд бодит эдийн засаг руу нийлүүлэгдэх санхүүжилт нэмэгдэж, зээлийн хүү буурсан нь эдийн засгийн сэргэлтэд чухал дэмжлэг боллоо. Түүнчлэн заавал байлгах нөөцийн хувь, эрсдэлийн жингийн тохируулгуудаар дамжуулан эдийн засаг дахь долларжилтыг маш бага түвшинд хүргээд байна. Энэ нь банк, ААН-ийн ханшийн эрсдэлд өртөх эмзэг байдлыг бууруулж байна. Банкны салбарын хяналт шалгалтыг сайжруулж, банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхийн тулд хяналт шалгалтын

зарчмуудыг өөрчилж, мөрдүүлж эхэллээ. Мөн банкны системийн активын чанарын үнэлгээний үргэлжлэл болгож магадлан итгэмжлэх аудитыг хийж дуусгалаа. Монголбанкны институцийн хөгжлийг шат ахиулж, дархлааг бий болгохын тулд мөнгөний бодлогын шийдвэр гаргах зарчмаас эхлээд банкны хяналт шалгалт, үндэсний төлбөр тооцооны тогтолцоо, хадгаламжийн даатгалын тогтолцоо, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах ажлыг банк, санхүүгийн салбарын тулгуур хуулиудад өөрчлөлт оруулах, эрх зүйн зарим зохицуулалтыг шинээр боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, тэдгээрийг хэрэгжүүлж эхлээд байна. Цаашид ч хийх ажлуудыг энэ жилийн үндсэн чиглэлд тусгасан.

3. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл юунд зорьж байна вэ.Өмнөх жилүүдээс онцлох шинэлэг зүйл нь юу байна вэ?

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Монголбанк өөрийн тооцоо, судалгаа, холбогдох мэргэжлийн байгууллага, бие даасан судлаачид, олон улсын байгууллагуудын зөвлөмж, дүгнэлтийг харгалзан үзсэн. Мөнгөний бодлогын баримт бичигт эдийн засгийн сэргэлтийн төлөв, ирэх жилүүдэд эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэл, сорилтыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх чиглэлд анхаарал хандуулсан зорилтуудыг тусгалаа. Тухайлбал, гадаад өрийн

эргэн төлөлтийг шийдвэрлэх, эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд валютын цэвэр нөөц, түүний хүрэлцээг нэмэгдүүлэх, гадаад өрийн тулсан дарамтуудыг шийдвэрлэх нь нэн тэргүүний зорилт болж байна. Ялангуяа, ирэх онд эдийн засгийн өсөлтийн үе үргэлжлэхээр байгаа тул гадаад, дотоод секторын тэнцвэртэй байдлыг хадгалах, валютын ханшийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх юм. Мэдээж хэрэг макро тогтвортой байдлыг хангахын тулд инфляцийг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ. Нөгөө талаас банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэтгэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Технологийн дэвшилтэй холбоотойгоор санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн шинэтгэлийг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4. Энэ жилийн үндсэн чиглэл нь дунд хугацааны сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэж байна. Харин ирэх жилийн эдийн засгийн төлөвийн талаар байр сууриа хуваалцана уу?

Эдийн засгийн өсөлтийг их консерватив хандлагаар авч үзвэл цэгэн үнэлгээгээр 5.6 хувь, интервал үнэлгээгээр 5.1-6.3 хувьтай байхаар байна. Энэ бол инфляцид дарамт багатай өндөр өсөлт гэж харж байна. Инфляцийн хувьд нийлүүлэлтийн, улирлын, төрийн зохицуулалттай барааны үнэ, зах зээлийн нийлүүлэлтийн

суваг, түүний хөгжил сул байгаатай холбоотойгоор цөөн тооны бараа, үйлчилгээний үнийн савлагаанаас хамааран хэлбэлзэл өндөр байгаа хэдий ч 2020 оны эцэст 7.2 хувь байх төлөвтэй байна. Эдийн засгийн дотоод талаас сүүлийн 2-3 жилд хуримтлуулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хүртэх, өрхийн болон Засгийн газрын хэрэглээ эдийн засгийн дотоод эрэлтийг дэмжихээр байна. Гадаад орчны хувьд эрсдэл байна. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг олон улсын байгууллагууд бууруулж, түүхий эдийн үнэ сулрах хандлага үргэлжилж байна. Худалдааны маргаантай холбоотой тодорхой бус байдал, зах зээл дээрх савлагаанууд үргэлжилсээр л байна. Аль ч тохиолдолд эдийн засгийн секторууд одоо үргэлжилж буй гадаад, дотоод таатай боломжийг ашиглан санхүүгийн эрсдэл даах чадвараа нэмэгдүүлэх нь тогтвортой байдлын сайн сонголт болж байна.

5. Ирэх жилийн эдийн засгийн төлөв харьцангуй сайн байх нь ээ. Харин эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлөх сорилтууд, шийдвэрлэх асуудлуудыг хэрхэн үзэж байна вэ?

Эдийн засгийн цаашдын төлөв байдлыг авч үзвэл эдийн засгийн сэргэлт үргэлжилж, инфляци зорилтот түвшний орчимд хадгалагдахаар хүлээгдэж байгаа хэдий ч эдийн засагт ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай сорилтууд байна. Тухайлбал, Монгол улс 2020-2024 оны хооронд төр болон хувийн хэвшлийн нийт 14 орчим тэрбум

ам.долларын өрийн асуудлыг амжилттай шийдвэрлэх нь хамгийн чухал. Саарал жагсаалтад орсон ч, эс орсон ч УИХ, ЗГ, Шүүх эрх мэдлийн байгууллагууд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хамтран энэ талын ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, олон улсын өмнө хүлээх хариуцлагаа биелүүлэх ёстой. Томоохон төслүүдийг хөдөлгөхдөө богино хугацаанд эдийн засагт хүндрэл дагуулахгүйн тулд гадаад эх үүсвэрт тулгуурлаж шийдвэрлэх хэрэгтэй. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн дэлхий даяар өрнөж байна. Иймд зөвхөн гадаадын төдийгүй дотоодын хөрөнгө оруулагчдаа ч дэмжих шаардлагатай. Эдийн засгийн бодлого туйлын прагматик байх шаардлагатай болсон. Эдийн засгийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, ниргэсэн хойно нь хашгирахгүйн тулд дэлхийн эдийн засгаас ирж болзошгүй сөрөг нөлөөг давах бэлтгэлээ төр, хувийн хэвшил, иргэдийн түвшинд хангах, түүнийг хангуулах чиглэлд ирээдүйг харж бодлого, зохицуулалтаа төрийн байгууллагууд чиглүүлэх шаардлагатай байна. Энэ бүхнийг шийдвэрлэхийн тулд олон улсын санхүүгийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид, донор улс орнуудтайгаа ойлголцож, харилцаагаа маш сайн өндөр түвшинд хадгалах шаардлагатай.

Танд баярлалаа.

2020 ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БАРИМТЛАХ

Мөнгөний бодлого нь эдийн засгийн болон байдлыг бэхжүүлж, санхүүгийн зах з

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1 Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2020 онд жилийн 8 хувьд, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

1.2 Банкны системийн эрдсэлийг үнэлэх, санхүүгийг мөчлөгийг тодорхойлох шинжилгээний аргачлалыг үргэлжлүүлэн хөгжүүлж, системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3 Мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах зорилгоор Төв банкны олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлж, мэдээллийн хүртээмжийг сайжруулна.

2. Санхүүгийн тогтвортой хүрээнд:

2.1 Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.

2.2 Банкны салбарын чадварыг нэмэгдүүлж, эзэмшлийн төвлөх зохистой засаглалын нийтийн оролцоо болгох эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой
хөгжлийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

ийн салбарын
ий байдлын
ээнд:


2.3 Банкны хяналт
шалгалт, зохицуулалтын
арга хэрэгслийг
Базелийн стандарттай
нийцүүлэн сайжруулах
арга хэмжээг авна.

арын эрсдэл даах
мэгдүүлэх, хувь
өрлийг бууруулах,
алын зарчим, олон
доо, хяналтыг бий
орчныг бүрдүүлэх
үе шаттай авч
жүүлнэ.

3.1 Үндэсний
төлбөрийн системийн
нэгдсэн зохицуулалтыг
бий болгох, төлбөрийн
систем дэх финтек
компаниудын үйл
ажиллагааг
зохицуулсан эрх зүйн
зохицуулалтыг
шинэчилнэ.

**3. Санхүүгийн захын
дэд бүтэц, түүний
институцийг бэхжүүлэх
хүрээнд:**


1 **3**
3.3 Олон нийтийн
санхүүгийн суурь
мэдлэгийг
дээшлүүлэхэд
чиглэсэн үйл
ажиллагааг дахин
эрчимжүүлнэ.

3.2 Төв банкны суурь бүртгэлийн
болон дотоод удирдлагын цогц
системийг нэвтрүүлж, бүртгэл,
удирдлага, хяналт, тайлагналыг
олон улсын жишигт хүргэн,
мэдээллийн технологийн
хөгжлийн шилдэг туршлагыг
нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... (2019.09.17)

Мөнгөний бодлогын хороо 9 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаж, бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Уг шийдвэрийг танилцуулах хэвлэлийн бага хурлын үеэр Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн асуултад хариулсныг хүргэж байна.

БЛҮҮМБЭРГ ТВ:

2-р улирлын мөнгөний бодлогын мэдэгдэлд санхүүгийн нөөц, хуримтлалыг бүрдүүлэх нь чухал гэдгийг дурдсан байсан. Ирэх оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төсөл ч бас энэ чиглэлд ихээхэн анхаарсан байна. Монгол Улс 2021 оноос их дүнтэй өр, төлбөрүүдээ төлж эхэлнэ. Энэ ачааллыг дан ганц хуримтлалын хүчээр даван гарах боломжтой юу. Хуримтлал бүрдүүлэхээс өөр ямар гарц байж болох вэ?

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч
О.ЭРДЭМБИЛЭГ:

Манай улсын мөнгө болон төсвийн бодлого нь дунд хугацаанд буюу 2020-2024 онд төлөх өрийн удирдлагатай шууд холбогдож байна. Энэ утгаараа хуримтлал үүсгэх шаардлагатай. Бодлогын бүх чиглэлээр, бүх дансанд хуримтлал үүсгэх ёстой. Тухайлбал, санхүүгийн салбарт банкуудын өөрийн хөрөнгийг 100 тэрбум төгрөг болгох шаардлагыг Монголбанкнаас тавьсан. Долоодугаар сард Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн журамд өөрчлөлт орсон. Энэ нь банкны салбарт эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж байгаа үе шаттай арга хэмжээнүүдийн нэг юм. Тэгэхээр бид үе шаттайгаар, 3 жилийн хугацаанд банкууддаа буюу бодит секторт очих зээлийн хэмжээнд ачаалал өгөлгүйгээр, эдийн засаг тогтвортой өсөх боломжийг хангасан зохицуулалтуудыг хийгээд явж байна. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд орсон өөрчлөлтийн нэг хэсэг нь энэ оны 7 дугаар сарын 1-ээс

хэрэгжиж эхэлж байгаа бол бас нэг хэсэг нь 10 дугаар сарын 1-ээс, цаашилбал, 2020 оны 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхлэх хэдий ч зохицуулалтууд бий. Энэ арга хэмжээнүүд нь Монголбанкны зүгээс бодит секторыг болон санхүүгийн зуучлалын бизнесийг дэмжсэн, зөв зохистой дэд бүтцийг бий болгохын тулд хийгдэж байгаа юм. Төв банкны алдагдлыг бууруулж байгаа нь ч бас тэдгээр арга хэмжээнүүдийн нэг. Хуримтлалыг бий болгохгүйгээр дунд хугацаанд төлөгдөх өрийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй. Хуримтлал үүсгэхгүйгээр шийдэж болох уу гэвэл мэдээж боломж бий. Гэхдээ хуримтлал үүсгэснээр ачааллыг илүү бууруулах боломжтой гэж үзэж байгаа юм.

БЛҮҮМБЭРГ ТВ

8 дугаар сарын инфляци Улаанбаатар хотын хэмжээнд 10.5 хувьд хүрсэн нь сүүлийн 4 жилийн хамгийн өндөр түвшин болоод байна. Үүний бараг тал хувийг нийлүүлэлтийн гаралтай бараа, бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлсэн. Төв банк Засгийн газраас хараат бус ажиллах ёстой хэдий ч ЗГ-тай хамтраад нийлүүлэлтийн хүчин зүйлс дээр ажиллах, бодлогын зөвлөмж өгч байгаа юу?

Мөнгөний бодлогын газрын захирал **Б.БАЯРДАВАА:**

Инфляци Улаанбаатар хотын хэмжээнд 10.5 хувьд хүрсний дийлэнхийг нийлүүлэлтийн шинж чанартай хүчин зүйл бүрдүүлж байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, манай эдийн засгийн улирлын онцлог, цаг агаарын хүчин зүйл нөлөөлж байна. Тухайлбал, ургац хураалттай холбоотойгоор хүнсний ногооны үнэ өдийд

нэлээд буурдаг байтал энэ жилийн хувьд бага зэрэг хойшлогдсон дүр зураг бий. Мөн их, дээд сургуулиудын төлбөр 8 дугаар сард дунджаар 11 хувиар өссөн байна. Зуны саруудад төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүн буюу цахилгаан, дулааны үнэ аажмаар нэмэгдсэн нь нөлөөллөө. Сүүлийн үед бензиний үнэ харин харьцангуй тогтвортой байна. Дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ тогтвортой байсан ч сүүлд Саудын Арабт болсон арга хэмжээтэй холбоотойгоор эргээд 67-68 ам.доллар болоод өсчихлөө. Энэ нь цаашдаа инфляцид нөлөөлж болзошгүй хүчин зүйлс болохоор байна. Монголбанкны зүгээс Засгийн газартай тодорхой нийлүүлэлтийн гаралтай бараа, бүтээгдэхүүний үнийг зохицуулах талаар зарим нэг зөвлөмж өгдөг. Тухайлбал, нефтийн үнийг яаж тогтвортой барьж болох талаар бусад улсад туршигдаж, амжилттай хэрэгждэг санхүүгийн дериватив, хеджинг хэрэгслүүдийг ашиглах санал, зөвлөмж өгсөн. Үүний гол агуулга нь дэлхийн зах зээл дэх үнийг манай дотоодын зах зээл дэх бензиний үнэ дагаж хөдөлж байгаа нь манай улсын хувьд зах зээл дээр хеджинг хийх боломжийг олгож байгаа. Энэ боломжийг ашиглаад, олон улсын зах зээл дээр тэртээ тэргүй дериватив бүтээгдэхүүний хэрэгсэл нь квотлогдоод байж байдаг учраас, түүнийг ашиглаад, үнийн савлагаанаас үүсч байгаа эрсдэлийг олон улсын зах зээл дээр нь үүрүүлэх боломж бий. Энэ саналыг бид Засгийн газарт өнгөрсөн оны сүүлээр хүргүүлсэн.

Үүнээс гадна сүүлийн үеийн инфляцийн хөдөлгөөнийг харвал нийт инфляцийнхаа 40 орчим хувь нь нэг удаагийн, улирлын шинжтэй хүчин зүйлсээс болж, инфляци маш их савлаж байна. Тэгэхээр тодорхой нэг зүйл нь юу байна вэ гэхээр нийлүүлэлтийн шинжтэй инфляцийг мөнгөний бодлогоор засах арга байхгүй. Үүнийг шийдэх арга нь юу вэ гэхээр аливаа төрлийн савлагаа үүсээд байгаа бүтээгдэхүүний зах зээлийн дэд бүтэц, өртгийн сүлжээ, нийлүүлэлтийн сүлжээг сайжруулж байж л асуудлыг шийдвэрлэнэ.

SBN ТЕЛЕВИЗ:

Монгол Улсын гадаад өр ДНБ-ий хэдэн хувьтай тэнцэж байгаа вэ. Өнгөрсөн жилийн хувьд АХБ, ДБ-ны гаргасан судалгаа нь Монголбанкны гаргасан судалгаагаас 10 орчим хувиар зөрж байсан. Үүнд тайлбар өгнө үү?

Монголбанкны Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИР:**

Монгол Улсын нийт гадаад өр 29.7 тэрбум ам.доллар. ДНБ-ий 220.5 хувьтай тэнцүү байна. Олон улсын байгууллагуудын гаргаж байгаа тооны хувьд тодруулж хэлэхэд Монгол Улсын албан ёсны нийт гадаад өрийн статистикийг Монголбанк гаргаж, олон улсын байгууллагуудад хүргүүлдэг. Нийт өрийн статистик дотор улсын сектор, тэр дундаа Засгийн газрын өр гэх ангиллууд бий. Манай улсын засгийн газрын мөрдөж, төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа дээд хязгаарыг мөрдүүлж байгаа тооны хувьд Засгийн газрын яг өөрийнхөө нэрээр авсан зээлүүдийг хамруулдаг. Харин олон улсын тодорхойлолтоор бол үүнд улсын сектор буюу төрийн өмчит байгууллага, Хөгжлийн банк зэргийн өрийг нэмж тооцохоор өөр дүн харагдаад байгаа юм.


25 ТВ:

Гадаад өрийн тухайд ойрын хугацаанд хийгдэх томоохон өр, төлбөрүүдийг дахин санхүүжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа юм байна. Тэгэхээр хүүгийн нөхцөлийг сайжруулах, одоогийнхоос дордуулахгүй байх боломжтой юу. Засгийн газар болон хувийн хэвшил яг ямар дүнтэй хэдий хэмжээний төлбөрүүдийг төлөх хуваарьтай байгаа вэ?

Монголбанкны Ерөнхий эдийн засагч **Д.ГАН-ОЧИР**


2024 он хүртэл төлөх нийт гадаад өрийн хэмжээ 14.5 орчим тэрбум ам.доллар байна. Үүнээс 5 орчим тэрбум ам.доллар Засгийн газрын гадаад өр байгаа. Монголбанкны хувьд Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийн өнөөгийн түвшинг гадаад өрийн эргэн төлөлттэй харьцуулаад үзвэл нөөцийн хүрэлцээ бага байгаа. Тийм учраас гадаад өрийг дахин санхүүжүүлэх шаардлага бий. Үүний тулд хүү болон бусад нөхцөлийг одоогийнхоос дордуулахгүй байх шаардлагатай. Үүний тулд зээлжих зэрэглэлээ муутгахгүй байх, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, Засгийн газар төсвийн алдагдлыг нэмэхгүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах зэрэг ажлуудыг хийх шаардлагатай. Мөн олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгийг үргэлжлүүлэн авах нь маш чухал гэдгийг бид 2017 оны сургамжаар олж авсан. Тэгэхээр олон улсын санхүүгийн байгууллагууд болон донор санхүүгийн байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах, тэдний өмнө хүлээсэн амлалтуудаа тууштай биелүүлэх ёстой.

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц



- М2 мөнгөний жилийн өсөлт 17.4%-д хүрч 20.5 их наяд төгрөгт хүрэв.
- Өмнөх сараас 0.9%-иар буюу 185.8 тэрбум төгрөгөөр өсөв. Үүнээс М1 мөнгө 4.0% (151.7 тэрбум) –иар, бусад хадгаламж 0.2% (34.1 тэрбум) –иар өссөн байна.
 - М1 → Төгрөгийн харилцах 143.3 тэрбумаар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 8.4 тэрбумаар өсөв.
 - Бусад хадгаламж → Төгрөгийн хадгаламж 45.2 тэрбум аар буурч, гадаад валютын хадгаламж 18.2 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах 61.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Мөнгөний үзүүлэлт

Зээл

Ипотекийн зээл

Хүү

Гадаад сектор


Түүвэр судалгаа

Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



- Нийт М2 мөнгөний нийлүүлэлтийн 53%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 16%-ийг төгрөгийн харилцах, 14.4%-ийг гадаад валютын хадгаламж, 13.4%-ийг гадаад валютын харилцах, үлдсэн 3.2%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд төгрөгт хүрснээс 84.3%-ийг иргэдийн хадгаламж, 15.7%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 21.5%-ийг, байгууллагын хадгаламжийн 20.5%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1.4. Нийт хадгаламж



Мөнгөний үзүүлэлт

Зээл

Ипотекийн зээл


Хүү

Гадаад сектор

Түүвэр судалгаа


2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 15%-иар өсч 18.1 их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 18%-иар өсч 9.3 их наяд төгрөгт,
- Хувийн байгууллагынх 10%-иар өсч 8.7 их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн 13%-ийг, Иргэдийн зээлийн 1.6%-ийг, Хувийн байгууллагын зээлийн 25%-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

Зураг 2.2. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь



Мөнгөний үзүүлэлт

Зээл

Ипотекийн зээл

Хүү

Гадаад сектор

Түүвэр судалгаа

2. Зээл

Зураг 2.3. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



Зураг 2.4. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл 18.1 их наяд төгрөг (Төгрөгийн зээл 15.8 их наяд, Гадаад валютын зээл 2.3 их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас 23 тэрбум буюу 0.1%-нар буурсан.
- Хэвийн зээл өмнөх сараас 107 тэрбум буюу 0.7%-нар буурсан.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 104 тэрбум буюу 11.9%-нар өссөн.
- Чанаргүй зээл өмнөх сараас 19.8 тэрбум буюу 1%-нар буурсан байна.


Мөнгөний үзүүлэлт > Зээл > Ипотекийн зээл > Хүү > Гадаад сектор > Түүвэр судалгаа

3. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү



Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээл, хүү




- Иргэдээс татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.6%, хувийн байгууллагаас татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 10.6% байна.
- Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.5%, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.8% байна.

Мөнгөний үзүүлэлт > Зээл > Ипотекийн зээл > Хүү > Гадаад сектор > Түүвэр судалгаа

Төлбөрийн тэнцэл > Гадаад сектор

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 7 сар



Мөнгөний үзүүлэлт > Зээл > Ипотекийн зээл > Хүү > Гадаад сектор > Түүвэр судалгаа

ҮНИЙГ ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Амьжиргаа ба үнэ

21-р зуунд ихэнх хүмүүс өөрсдийн хэрэгцээт зүйлсээ дэлгүүрээс худалдаж авдаг болсон. Энэ нь хоол хүнснээс эхлээд хувцас хунар, орон байраа хүртэл бүгдийг өөрөө хийдэг эрт дээр үеэс ялгаатай юм. Хэрэглээний бүхий л зүйлээ өөрөө бэлдэх бус, зах зээл дээрээс худалдаж авдаг 21-р зууны амьдралд бараа үйлчилгээний үнэ иргэдийн амьжиргаанд чухал нөлөөг үзүүлдэг. Иймд үнэ хэрхэн өөрчлөгдөх нь аливаа улсад чухал эдийн засгийн үзүүлэлт болдог байна. Жирийн нэг дэлгүүрт ороод харахад л зах зээл дээр маш олон төрлийн бараа үйлчилгээ бий гэдэг нь ойлгогдоно. Тэгвэл зарим барааны үнэ нэмэгдэж, зарим нь хямдарч байгаа нөхцөлд бидний амьжиргаанд үнэ хэрхэн нөлөөлж байгааг мэдэх амаргүй юм. Иймд эдийн засагчид дундаж өрхийн хамгийн түгээмэл хэрэглэдэг зүйлсийг багц болгон “хэрэглээний сагс” үүсгээд, сагсанд багтсан бараа үйлчилгээний үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж байгааг ажигладаг. Эдийн засаг дахь үнийн түвшний ерөнхий өөрчлөлт буюу хэрэглээний сагсны үнийн өөрчлөлтийг инфляци гэж нэрлэх

нь түгээмэл юм. Хэрэглээний сагсны бүтэц нь аливаа улсын онцлогоос хамаарна. Тухайлбал нэг хүнд ногдох жилийн орлого нь \$40 мянга давсан Японд хэрэглээний сагс нь 580 орчим бараа үйлчилгээнээс бүрддэг байна. Харин Монгол айл өрхүүдийн хэрэглээг 370 орчим төрлийн бараа үйлчилгээгээр төлөөлүүлдэг. Мөн аль бараа үйлчилгээ өрхийн зардлын гол хэсгийг бүрдүүлдгээс хамаарч сагсанд эзлэх жин, инфляцид үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал хөгжсөн орнуудад өрхүүд хэрэглээний зардлынхаа 10% хүрэхгүйг хүнсэнд зарцуулдаг бол монгол өрхүүдийн хувьд хэрэглээний зардлын 10% нь зөвхөн мах байдаг. Иймд махны үнийн өөрчлөлт инфляцид, айл өрхийн амьжиргаанд чухал нөлөөтэй байна. Хэрэглээний сагсны үнийн өөрчлөлт цалин орлогын өсөлтөөс хурдтай нэмэгдсэн тохиолдолд худалдан авах чадвар муудаж амьжиргаа доройтож буйн илрэл тул орлогын өсөлтийг үнийн өсөлтөөс өндөр байлгах нь чухал юм.

Үнэ ба эдийн засаг

Зах зээлийн тогтолцоонд

үнэ хэмээх үзүүлэлт бизнесийн үйл ажиллагаа, эдийн засаг хэр идэвхтэй өрнөж буйг илэрхийлдэг үзүүлэлт болдог. Аливаа барааны үнэ өсч байгаа нь нэг талаас хэрэглэгчдийн худалдан авах чадвар сайн байгаагийн илрэл юм. Харин бизнес эрхлэгчдийн өнцгөөс харвал эрэлт өндөртэй, үнэ нь өсөлттэй байгаа тухайн бараа үйлчилгээг үргэлжлүүлэн үйлдвэрлэх, хэрэглэгчдэд зарж борлуулах хөшүүрэг болдог. Борлуулалт сайн байна гэдэг нь компани аж ахуйн нэгжүүдэд ажиллагсдын цалин орлого нэмэгдэж, эргээд зах зээл дээрээс бараа үйлчилгээ худалдан авах чадвар нэмэгдэнэ гэсэн үг юм. Иймд эдийн засагт үнийн ерөнхий түвшин буюу инфляци өсөлттэй байна гэдэг нь иргэдийн цалин орлого өсөлттэй, үйлдвэрлэл үйлчилгээ идэвхтэй өрнөж буйн илэрхийлэл болдог.

Гэвч компани аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэх, борлуулах чадвараас давсан эрэлт бий болох нь үнийн хэт хөөрөгдлийг үүсгэх эрсдэлтэй. Мөн цаг агаар, тээвэрлэлт, түүхий эдийн хомсдол зэрэг нийлүүлэлтийн шалтгаанаар үйлдвэрлэж буй бараа



бүтээгдэхүүний үнэ хурдтай өсөх тохиолдол бий. Тухайлбал, ургац алдсанаар хүнсний үнэ огцом өсөх тохиолдлыг нэрлэж болно. Хөгжиж буй орнуудын хувьд зам дэд бүтцийн хөгжил тааруу, үйлдвэрлэлийн багтаамж бага зэргээс шалтгаалан нийлүүлэлтийн гаралтай инфляцийн хэлбэлзэл их байх нь түгээмэл байдаг.

Үнэ ба зохицуулалт

Үнэ хэдийгээр айл өрхийн амьжиргааны түвшинд чухал нөлөөтэй ч, өөрчлөлтгүй тогтмол байх эсхүл үнийн түвшин буурч дефляци үүсэх нь эдийн засагт сайнгүй юм. Үүний нэг жишээ нь ЗХУ-ын үеийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, эсвэл дефляци урт хугацаанд асуудал болж буй Японы эдийн засаг юм. Үнийг төрөөс тогтоодог ЗХУ-ын тогтолцооны үед үнэ тогтмол тул зах зээл дээрх эрэлт ба нийлүүлэлтийг тэнцвэртэй байлгах, эдийн засгийн идэвхжлийн байдлыг илэрхийлэхээ больсон байдаг. Улмаар зарим бараа илүүдэл нийлүүлэлттэй, харин зарим бараа хомсдолтой учраас дэлгүүрт урт дараалал их үүсдэг байв. Энэ нь эцэстээ эдийн засаг үр ашиггүйгээс болж нурж унахад

хүргэсэн байдаг. Харин Японы эдийн засгийн хувьд, хүн ам хурдтай хөгширч цөөрч байгаа тул худалдан авалт буурч, эдийн засаг нь дефляцийн дарамтанд удаан хугацаанд явж байна. Энэ нь бизнесийн байгууллагуудын борлуулалтад сөргөөр нөлөөлж, шинээр хөрөнгө оруулалт хийхгүй байх, үйл ажиллагаагаа тэлэхгүй болох, улмаар эдийн засгийн идэвхжил саарах зэрэг үр дүнд хүргэжээ. Түүнчлэн, инфляци өсөхгүй байх, дефляци бий болох нь өр төлбөртэй хүмүүсийн хувьд хүндээр тусдаг. Учир нь инфляцийн нөлөөгөөр мөнгөний үнэ цэнэ унахгүй тул өрийн дарамт ихэсдэг байна. Эсрэгээрээ, үнэ хурдтай өсөх нь өрхийн амьжиргааг доройтуулж ядуурал болон нийгмийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх, мөнгөний үнэ цэнийг унагаснаар хадгаламж эзэмшигчийг хохироож, бизнесийн байгууллагууд ч төлөвлөлтөө хийхэд саад учруулдаг. Иймд үнэ хэт хурдтай өсөх бус, тогтмол байх бус, буурах бус харин тогтвортой бөгөөд нам түвшинд өсөлттэй байх нь эрүүл эдийн засгийн шинж тэмдэг юм. Үүнийг макро бодлогоор зохицуулдаг бөгөөд эдийн засгийн идэвхжил,

орлогын өсөлт ба инфляцийн зохистой түвшнийг хадгалахад төв банкууд мөнгөний бодлогоор зохицуулалт хийдэг. Мөнгөний бодлого ямар нэгэн бүтээгдэхүүний үнийг тодорхой түвшинд байлгахыг зорьдоггүй бөгөөд, үнийн ерөнхий түвшний өөрчлөлтийг анхаардаг байна. Харин зарим бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн гаралтай үнийн огцом хэлбэлзлийг тогтвортой байлгахад Засгийн газрууд анхаардаг. Тухайлбал, ядуу эмзэг бүлгийг үнийн өсөлтөөс хамгаалахад чиглэсэн халамжийн бодлого хэрэгжүүлэх, хүнс болон тог цахилгаан, бензин гэх мэт онцгой чухал бараа бүтээгдэхүүн дээр салбар хариуцсан яамнаас нийлүүлэлтийн болоод үнийн зохицуулалт хийх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар үнэд үзүүлэх нөлөөллийг багасгах гэх мэт арга хэмжээг дурдаж болно. Гэхдээ эдгээр арга хэмжээ нь зах зээлд томоохон гажуудал үүсгэхгүй байх, улсын төсөвт буюу татвар төлөгчдийн нуруун дээр том дарамт учруулахгүй байх нь чухал юм.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГАРАЛТАЙ ИНФЛЯЦИЙГ ХЭРХЭН ЗОХИЦУУЛАХ ВЭ?



Н.УРГАМАЛСУВД

Монголбанкны МБГ-ын
Мөнгөний бодлого, төсөөллийн
хэлтсийн захирал

Монголбанк бодлогын шинжилгээг улирал бүр хийдэг. Өмнөх удаагийн инфляцийн төсөөллийг нэмэгдүүлж, 8 орчим хувь болгосон байгаа. Учир нь нэгдүгээрт, Улаанбаатар хотын инфляци 8 дугаар сарын байдлаар 10.5 хувьд хүрсэнтэй холбоотой. Үүний 3 нэгж хувийг махны үнийн өсөлт бүрдүүлж байна. Махны үнийн өсөлтийн улирлын хандлага нь жил бүрийн долоодугаар сараас эхлээд, найм, есдүгээр сард үргэлжлэн буурдаг байсан бол энэ жил хуучин шигээ байсангүй. Тухайлбал, долоодугаар сард үнэ нь өссөн. Үргэлжлээд наймдугаар сарын эхний 3 долоо хоногийн турш өсч байгаад, сүүлийн долоо хоногт нь бага зэрэг буурсан. Есдүгээр сард мөн бага зэрэг буурсан. Гэхдээ энэхүү буурсан түвшин нь бидний төсөөлснөөс хамаагүй өндөр түвшинд хүрээд байна. Хоёрдугаарт, төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний үнэ сүүлийн саруудад нэлээд өслөө. Дулаан, цахилгааны үнэ түүнчлэн дээд боловсролын төлбөр нэмэгдсэн нь инфляцийн 0.8 нэгж хувийг бүрдүүллээ. Эдгээр нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляци юм. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бид өмнөх төсөөллөөр оны төгсгөлд буурна гэж үзэж байсан. Гэвч энэхүү бууралт нь бидний төсөөллөөс харьцангуй бага байгаа учраас инфляцийн төсөөллийг нэмэгдүүлсэн. Харин эрэлтийн шалтгаантай инфляцийн хувьд харьцангуй тогтвортой хэвээр байгааг онцлох хэрэгтэй. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн хувьд ихэнх нь богино хугацааны, түр зуурын шинж чанартай байдаг. Гэсэн ч зарим нэг нь дэд бүтэцтэй холбоотойгоор урт хугацаанд үйлчлэх эрсдэлтэй. Төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний хувьд дахиж үнэ нь өсөхгүй. Тэгэхээр энэ удаагийн өсөлтийн нөлөөлөл нь 12 сарын дараа арилна. Харин махны үнийн хувьд экспортын эрэлттэй холбоотойгоор дотооддоо өсч байгаа. Засгийн газрын зүгээс бодлогын зохицуулалтуудаа хийгээд явж байгаа гэж ойлгож байна.



Г.БУМЧИМЭГ

Монголын эдийн засгийн
шинжилгээ, судалгааны
төвийн захирал

Монголбанкны хүрч чадах хэсэг нь эрэлтийн гаралтай инфляци. Нийлүүлэлтийг зохицуулах гэж оролдвол зах зээл дээр гажуудал үүсгэдэг. Өмнөх жилүүдэд махны, гурил будааны нийлүүлэлтийг хангах зорилгоор хямд санхүүжилт олгож байсан туршлага бий. Энэ бол төв банкны өөрийнх нь ажил үүрэгт хамаарахгүй асуудал. Аль ч улсын төв банк эрэлтийн гаралтай инфляцийг л харж, удирдаж байдаг. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн хувьд махны үнийн өсөлт нэлээд их хувийг нь тайлбарлаад байгаа. Үүнд юуг анхаарах хэрэгтэй вэ гэхээр хэрвээ махыг экспортод гаргая гэж байгаа нөхцөлд махны дотоодын үнэ экспортын үнэтэй дүйцэх ёстой. Үүнийг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Махны стандартаа сайжруулаад, их хэмжээгээр экспортолж байгаа бол бид тэр үнээр нь л мах авч иднэ гэсэн үг. Тэгэхээр орлогын хуваарилалт хотоос хөдөө рүү шилжиж байна. Энэ бол байх ёстой зарчим гэж харж байгаа. Гэхдээ мэдээж дотоодын махны үнэ дэлхийн зах зээлийн үнээс давахгүй. Үхрийн махны үнэ дэлхийн зах зээл дээр дунджаар кг нь 4.5 доллар байгаа. Монголын хувьд өнөөдөр тэр түвшиндөө л байна гэж харж байна. Тийм учраас цаашаа өсөхгүй болов уу гэж бодож байна. Монголбанкны хувьд нийлүүлэлтийн гаралтай буюу махны үнийн өөрчлөлтөд ямар нэгэн хариу үйлдэл үзүүлэхгүй байх. Монголбанкны хувьд суурь инфляци л харж, удирдаж байх нь зөв. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг хэрхэн зохицуулах вэ гэдэг нь Засгийн газрын шийдэх асуудал.

Инфляци энэ оны 8 дугаар сарын эцэст Улаанбаатар хотын хэмжээнд 10.5, улсын хэмжээнд 8.9 хувьтай гарч, Монголбанкны үндсэн зорилт болох 8 хувиас давсан үзүүлэлт гарсан билээ. Үүний 4 орчим нэгж буюу бараг талаас илүү хувийг нь нийлүүлэлтийн гаралтай мах, хүнсний ногоо, хатуу түлшний үнийн өсөлт бүрдүүлээд байгаа юм. Монголбанкнаас нийлүүлэлтийн гаралтай түр зуурын инфляцид хариу үйлдэл үзүүлж, бодлогын хүүг өсгөх буюу бууруулах шаардлагагүй гэж үзснээр бодлогын хүүгээ хэвээр хадгалах шийдвэр гаргаад байна. Өөрөөр хэлбэл, Монголбанкны бодлогын хэрэгсэл нь зөвхөн эрэлтийн гаралтай суурь инфляцид нөлөө үзүүлдэг. Харин нийлүүлэлтийн хүчин зүйлсийн тухайд хэрхэн зохицуулах талаар эдийн засагчид байр сууриа илэрхийллээ.



Н.ЭНХБАЯР

Эдийн засагч

Энэ оны хувьд инфляци 10-аас доош хувь руу орох байх. Монгол улсын эдийн засгийн онцлог, хүн амын тархац, суурьшлаас хамаараад хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт л бидний хувьд байнгын асуудал болдог. Хэрвээ бид нийслэлийн төвлөрлийн асуудлыг шийдэж чадсан бол ийм асуудал үүсэхгүй ч байж болох байсан. Хоёрдугаарт, хөдөө орон нутгаас нийлүүлж байгаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр ложистик, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлбэл, үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй байх боломж бий. Дээр нь бидний цаашид авах ёстой арга хэмжээ бол нэгэнт нийслэлийн хүн амыг бид 1-2 сая болно гэж тооцоолоогүй. Тийм учраас энэ 1-2 сая хүний мах, сүүний хэрэгцээг сар бүр тогтмол хангахын тулд зөвхөн дотоодын фермерээр хийх боломжгүй. Тэгэхээр бусад улсын жишгээр бол үүнийг импортын орцоор тодорхой хэмжээнд нөхөх боломжтой. Хаврын улиралдаа дутагдаж байгаа үед нь зөвхөн дотоодын хэрэгцээгээр бус импортоор хэрэгцээгээ нөхөж болно. Бусад улс оронд ингэж л шийддэг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарц ихтэй зун, намрын улиралдаа дотоодын бүтээгдэхүүнээр түлхүү хангах замаар инфляци зохистой түвшинд удирдаж болно. Мах экспортолж байгаа учраас үнэ өсч байгаа гэдэг. Гэтэл манай махны экспорт идэвхтэй хугацаа нь 3-4-хөн сар. 10-12 сарын туршид тогтвортой хийгддэг махны экспорт биш л дээ. Тэгэхээр маш бага, нийтдээ 100 гаруй сая долларын мах экспортолж байна. Энэ харьцангуй маш бага, жижигхэн тоо. Үүнийгээ нэг дор худалдах биш. Тасралтгүйгээр, 12 сарын турш аажмаар худалдах, хөргөлт, зоорь, ложистикийн системээ сайжруулах тухай л асуудал юм. Экспорт хөгжиж байж, Монгол Улсын эдийн засаг төрөлжсөн эдийн засаг болно.



Б.ЭРДЭНЭБАТ

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхмийн багш, профессор

Нийлүүлэлтийн хувьд энэ маань ашигтай бизнес болох ёстой. Бусад улсын ижил төрлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг компаниудтай өрсөлдөхүйц хэмжээнд ашигтай ажилладаг, том бизнес болох ёстой юм. Тэгэхээр бид гадаад секторуудтай өрсөлддөг компаниудаа ижил нөхцөл бололцоогоор хангаж өгөх хэрэгтэй байна. Ингэснээр нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар, тоог нэмэх бололцоо бүрдэнэ. Хамгийн түрүүнд үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэж бий. Үйлдвэрлэл явуулахад хэрэгтэй газар, капитал, хүний нөөц зэргийн үнэ нь бусад улсынхтай харьцуулахад өрсөлдөхүйц байх ёстой. Тэгж байж, Монгол Улсад хүнсний, махны нийлүүлэлтийн хэмжээ өсөх боломжтой. Гэхдээ бид үнэ хэзээ ч тогтмол байдаггүй зүйл. Үнэ тогтвортой байх ёстой гэж үзсэн бүхэл бүтэн социалист систем маань нуран унасан. Тэр системээ санагалзаж байгаа мэт, үнийг тогтвортой байлгах гэсэн бодлого хэрэгжүүлэх хүсэлтэй хүн шийдвэр гаргагчдын дунд олон байна. Энэ маань тухайн зах зээл жам ёсоороо хөгжихөд сөргөөр нөлөөлж, зах зээлийн механизмыг гажуудуулах, дээр нь татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй зарцуулах зүйл рүү хөтлөх тал бий. Тэгэхээр бид аль ч төрлийн бизнес Монгол Улсын зах зээл дээр ашигтай ажиллах нөхцөл бололцоог л бүрдүүлж өгмөөр байна.

Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба

НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛ

Монгоний бодлогын үүднээс авч үзвэл хүмүүсийн хүлээлт нь банкны бодлогын зорилгод нийцэж байгаа бол банкийг найдвартай банк гэж хэлж болно.



Найдвартай байдал нь үйл ажиллагаатай шууд холбоотой бөгөөд үүнийг төв банк бодлогын, эсвэл үйл ажиллагааны зорилгодоо хүрэх болно гэсэн итгэл үнэмшил гэж тодорхойлж болно.



Төв банкны нэр хүнд, найдвартай байдал хоёр нягт холбоотой байдаг.



Нэр хүндийн эрсдэлийг оновчтойгоор удирдахад зайлшгүй шаардлагатай чухал алхам бол нэр хүндийн эрсдэлийг тодорхойлох, хянах хэрэгслийг бий болгох явдал юм. Энэхүү хэрэгслийг бий болгосноор урьдчилан сэрэмжлүүлэх систем шинээр бий болж буй эрсдэлийг тодорхойлох, түүхэн эрсдэлийн санг үүсгэж, нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг олгоно.

НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Оролцогч бүр банкны үйл ажиллагааны тодорхой талыг үндэслэн төв банкны нэр хүндийн талаар өөрийн гэсэн үзэл бодолтой байдаг.



Нэр хүндэл нөлөөлөх нөлөө нь үргэлж болзошгүй үр дагавар гэж тооцогддог тул Банк эрсдэлийн үнэлгээнд гол ангилалд багтдаг.



Төв банкны хувьд сонирхогч талууд банкны бодлого, үйл ажиллагааг хэр сайн ойлгож, дэмжиж, итгэж байгаа нь төв банкны нэр хүндийг өсгөх гол хүчин зүйл юм.



Нэр хүндийн эрсдэлтэй холбоотойгоор аль газар, хэлтгэ хариуцлага хүлээх нь хэцүү байдаг. Бусад эрсдэлийг удирдах замаар бууруулах нь боломжтой байдаг.



Нэр хүнд нь банкны удирдах албан тушаалтны зан байдал, ажил эрхлэх арга барил, ил тод байдал, олон нийтийн санал асуулгад хариу өгөх зэргээс шалтгаалдаг.



Эрсдэлийн удирдлагын алба нь төв банкны санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, удирдахад шаардлагатай арга хэрэгслийг боловсруулдаг.

НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛИЙГ ХЭРХЭН ҮНЭЛЭХ ВЭ?

Төвлөрлийг сааруулж, тодорхой бус байдлаар хэрэгжүүлэх бөгөөд нэр хүндийн эрсдэлийн бодлого, журамтай болж үүнийг дагаж мөрдөх. Энэ үе шатанд нэр хүндийн эрсдэлийг зохицуулах чиг үүрэг, системийн хэрэгсэл байхгүй байна.



Бүх үйл ажиллагааг уялдаа холбоог нэгтгэх үүднээс нэр хүндийн эрсдэлийг хариуцах нэгжийг бий болгох. Нэр хүндийн эрсдэл нь байгууллагын эрсдэлийн стратегийн нэг хэсэг болж, нэр хүндийн эрсдэлийн хороо байгуулагдана.



Нэр хүндийн эрсдэлийн менежментийг үндсэн үйл ажиллагаанд оруулна. Энэ нь ирээдүйн чиг хандлага, бусдын туршлагаас суралцах боломжийг олгодог бөгөөд стратеги нь нэр хүндтэй асуудлуудыг урьдчилан харж, тэдгээрийг багасгах явдал юм.



НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛ ТӨВ БАНКНЫ ХУВЬД ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Төв банкны нэр хүндийн эрсдэлийг тэг байна гэж хялбархан тооцож болно. Гэсэн хэдий ч аль ч төв банк нэр хүндэд эрсдэл учрахаас бүрэн зайлсхийж чадахгүй.	
Сайн нэр хүнд, найдвартай байдал нь бодлогын нөлөөг дээшлүүлдэг. Энэ нь инфляцид төвлөрсөн төв банкуудад хамааралтай бөгөөд найдвартай байдал нь инфляцийг бага, тогтвортой байлгахад тусалдаг.	
Иргэд төв банкны мөнгөний бодлого инфляцийг бага, тогтвортой түвшинд байлгахад үр дүнтэй байх болно гэж үзэж байгаа бол хүлээлт, зан үйлийнхээ дагуу өөрчлөнө. Энэ нь инфляцийн зорилтод хүрэхэд нөлөөлнө.	
Төв банкны хувьд найдвартай байдал нь мөнгөний системийг хуурамч гүйлгээнээс хамгаалах, төв банкны бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, эсвэл нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.	

Д.БАЯНЗУЛ: ТӨВ БАНКНЫ НЭР ХҮНДЭД ЗОРИУДААР ХАЛДАХ ҮЙЛДЭЛ НЬ НИЙТЭЭРЭЭ ҮҮРЭХ ЭРСДЭЛД ХҮРГЭДЭГ



Төв банкны үйл ажиллагааны эрсдэлд юуг тооцдог болохыг уншигчиддаа сонирхуулах үүднээс энэхүү ярилцлагыг толилуулж байна. Энэ сэдвээр Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны захирал Д.Баянзултай ярилцлаа. Бид ярилцлагын агуулгаа олон нийтийн Төв банкнаас хүлээх хүлээлтэд нэр хүндийн эрсдэл илүүтэй нөлөөлдөг болох тухайд хандууллаа.

Энэ тухай ярилцахын өмнө оршил болгож Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны үндсэн үүргийн тухай танилцуулна уу?

Манай алба бол Монголбанкны санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулж, хэрэгжилтийг хянах, эрсдэлийг оновчтой удирдахад шаардлагатай аргачлал, мэдээллээр хангах чиг үүргийн дагуу ажилладаг. Тухайлбал, санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтын бүтэц, харилцагч гадаадын банк санхүүгийн байгууллага, тэдгээрт олгох валютын хязгаарыг тодорхойлох, гүйцэтгэлийг тооцох, тайлагнах, төв банкны барьцаа хөрөнгийн бодлогыг тодорхойлж, барьцаанд авах хөрөнгийн шалгуурыг тогтоох, санхүүгийн

хөрөнгийг үнэлэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын хүрээнд Монголбанкны хэмжээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг.

Эндээс төв банкинд учирж болох эрсдэлийн талаар сонирхохгүй өнгөрч болохгүй гэж бодож байна?

Үүнийг ярихын тулд эрсдэлийн тухай тайлбарлах хэрэгтэй болно. Тэгэхээр аливаа үйл явдлын ирээдүйн үр дүн хүлээлтээс өөр байх тохиолдлыг эрсдэл гэж ойлгож болно. Харин эрсдэлийн удирдлага гэдэг нь тохиолдож болох бүхий л эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, зайлсхийх, хяналт тавих үйл явцын цогц ойлголт шүү дээ. Эрсдэлийг ерөнхийд нь санхүүгийн

болон санхүүгийн бус эрсдэл гэж ангилдаг. Санхүүгийн эрсдэлд зах зээлийн эрсдэл буюу хүү, ханшийн өөрчлөлт хамаарна гэсэн үг. Мөн үүн дээр зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл багтдаг. Тэгвэл санхүүгийн бус эрсдэлийн тухайд бол үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр, хүндийн, гео-политикийн гэх зэрэг эрсдэл орно л доо. Төв банкны хувьд эдгээр эрсдэлүүд нь бүгд учирч болзошгүй эрсдэлүүд гэж тооцдог.

Та сая нэр хүндийн эрсдэл гэж дурдлаа. Бидний ярилцах гол сэдэв маань үүнд чиглэхээр зорьсон шүү дээ. Тэгэхээр Төв банкинд нэр хүндийн эрсдэл яагаад чухал вэ?

Энгийнээр бол төв банкны талаарх ойлголт, хийж буй үйл ажиллагааных нь талаар олон

нийтийн дунд сөрөг мэдээлэл үүсэхийг нэр хүндийн эрсдэл гэж үздэг. Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд нэр хүндийн эрсдэлийг үндсэн эрсдэл гэж үздэггүй, харин бусад төрлийн эрсдэлээс үүдэн гардаг эрсдэл юм. Гэхдээ нэр хүндийн эрсдэл нь төв банкны хувьд үргэлж учирч болзошгүй эрсдэлд тооцогддог. Ялангуяа 2008 оны Дэлхийн санхүүгийн хямралаас хойш дэлхийд тэргүүлэгч төв банкууд үүнд илүүтэй анхаарч, эрсдэлийн үнэлгээний гол үзүүлэлтэндээ тусгах болсон.

Төв банкинд итгэх олон нийтийн итгэл буюу найдвартай байдал, хариуцлагатай байдал, ил тод байдал нь төв банкны нэр хүндэд шууд холбоотой ойлголтууд. Орчин үеийн Төв банкууд бодлогын зорилт, үйл ажиллагаа, түүний арга хэрэгслүүдийн талаар олон нийтэд нээлттэй ил тод тайлагнаж, олон нийтийн дунд байгаа буруу ташаа ойлголтыг засч залруулахад онцгойлон анхаарч ажилладаг болсон. Ил тод байдал нь зөвхөн төв банкны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлээд зогсохгүй төв банкны үйл ажиллагааг олон нийтийн зүгээс үнэн зөв, бодитой үнэлж цэгнэх боломжийг бүрдүүлж, төв банкны бодлогод итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой.

Нэр хүндийн эрсдэл нь валютын ханшийн тогтвортой байдал төдийгүй мөнгөний бодлогын хэрэгжилтэнд чухал нөлөөтэй юм байна гэж ойлголоо. Гэтэл манай улсын хувьд авч үзвэл удирдлагуудынх нь нэр хүндэд халдсан мэдээлэл нийгэмд байсхийгээд

л цацагддаг. Үүнээс болж мөнгөний бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг үү?

Үүнийг ярихын тулд тайлбар хэрэгтэй. Тодруулбал мөнгөний бодлого нь мөнгөний бодлогын шилжих сувгаар дамжин эцсийн зорилт болох инфляцийн зорилгод хүрч хэрэгждэг. Шилжих сувгуудын нэг нь инфляцийн талаарх олон нийтийн хүлээлт шүү дээ. Тиймээс бодлогын үр нөлөөгөө өндөр байлгахын тулд төв банкууд хүлээлтийг зөв зохистой удирдах шаардлагатай болдог. Төв банкны хувьд олон нийт болон төв банкнаас хараат бус шинжээчид төв банкны бодлого, үйл ажиллагааг хэр сайн ойлгож, дэмжиж, итгэж байгаа нь төв банкны нэр хүндийг өсгөх, эсвэл унагах гол хүчин зүйл болдог.

Тиймээс инфляцийг онилох мөнгөний бодлого хэрэгжүүлдэг төв банкууд бодлогын зорилтоо ханган ажиллахаас гадна инфляцийн зорилт, бодлого, үйл ажиллагааны талаар олон нийтийн өмнө тогтмол тайлагнаж, ил тод байдлыг хангах, улмаар төв банкинд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх замаар хүлээлтийг зөв зохистой удирдахыг зорьдог. Тэгэхээр бодлого, үйл ажиллагаа нь хаалттай, олон нийттэй нээлттэй харьцдаггүй төв банк нэр хүндийн эрсдэлд орж болзошгүй байдаг. Энэ нь бодлогын үр нөлөөг нь бууруулах эрсдэлтэй. Харин таны хэлсэнчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр төв банкны бодлого, үйл ажиллагаа, удирдлагын нэр хүндэд халдсан худал сөрөг мэдээллүүд цацагдах нь сая дурдсан сувгаар дамжин төв банкны нэр хүндийг

унагах, бодлогын найдвартай байдлыг алдагдуулах, цаашлаад бодлогын хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг урхагтай. Инфляци, ханш нь худалдан авах чадвар, бодит орлогоор дамжин хүн бүрийн халаасанд нөлөөлж байдаг учраас зардлыг нь нийтээрээ үүрнэ л гэсэн үг. Тэгэхээр төв банкны бодлогын зорилтоо ханган ажиллахад хөндлөнгөөс худал хуурмаг мэдээллээр нэр хүндэд нь зориудаар халдах явдал бол цаанаа өргөн хүрээг хамарсан эрдэл дагуулдаг тул ийм оролдлогууд дахин бүү давтагдаасай гэж хүсч байна.

Монголбанкны хувьд энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авдаг вэ, ялангуяа эрх зүйн зохицуулалт бий юу?

Ер нь бол нэр хүндийн эрсдэлийг үүсгэж буй үндсэн эрсдэлийг зөв удирдаж байж нэр хүндийн эрсдэл үүсэх боломжийг бууруулдаг. Өмнө дурдсанчлан төв банкны нэр хүндийн эрсдэлд оруулдаг гол хүчин зүйлийн нэг нь төв банкинд итгэх олон нийтийн итгэл алдагдах явдал. Тиймээс бид нээлттэй ил тод байдлыг хангахын тулд олон нийттэй харилцах харилцаандаа тогтмол анхаарсаар ирсэн. Тухайлбал, макро эдийн засаг, банк санхүүгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх, мөнгөний бодлогын хурлын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг тогтмол зохион байгуулж байна. Үүнээс гадна төв банкны зорилт, үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийн талаар иргэд, оюутан, сурагч, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, лекц хийж байна. Сэтгүүлчдийн эдийн



Монголбанкны Эрсдэлийн удирдлагын хамт олон

засгийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үе шаттай сургалтуудыг тогтмол хийж, салбарын мэргэжилтнүүдийн саналыг тусгах уулзалт хэлэлцүүлгийг давтамжтай зохион байгуулдаг. Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийн төрөл агуулгыг улам бүр сайжруулан олон нийтэд цаасан болон цахим хэлбэрээр түгээж байна. Гэх мэт олон нийттэй харилцах бүхий л сувгийг өргөн хүрээнд ашиглаж үйл ажиллагаа, бодлогын шийдвэрээ нээлттэй ил тод тайлбарлан таниулахад шат ахин ажиллаж байна. Дэлхийн төв банкууд олон нийттэй харилцах сонгодог харилцааг хөгжүүлэх болсон. Монголбанк ч үүн тийш зорьж байна.

Эрх зүйн зохицуулалтын тухай асуусан шүү дээ. Энэ тухайд бол санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлого, журам, олон нийттэй харьцах бодлогын баримт бичиг, комплаенсийн журам зэрэг дотоод эрх зүйн зохицуулалтын дагуу

эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Үүнд бидний ярьж байгаа энэ төрлийн эрсдэл хамаарна гэсэн үг.

Тэгвэл нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлдэг бусад орны туршлага ямар байдаг вэ?

Өндөр хөгжсөн улс орнуудыг харахад, энэ төрлийн эрсдэлийг удирдахад урьдчилан сэрэмжлүүлэх систем (Early Warning System)-ийг ашиглан шинээр үүсч буй эрсдэлийг тодорхойлох, түүхэн эрсдэлийн санг үүсгэх, дүн шинжилгээ хийх, өнгөрсөнөөсөө суралцах зэргээр урьдчилан сэргийлж байна. Үүнээс гадна нийтлэг ашигладаг загвар бол "Хамгаалалтын 3 шат" гэсэн загвар бий. Хамгаалалтын нэг дэх шатанд тухайн үйл ажиллагааг хариуцаж, өдөр тутам эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг газар нэгжүүд хамаардаг. Хамгаалалтын хоёр дахь шатанд эрсдэлийн удирдлага, хяналт, комплаенсийн стандартыг тогтоох, хянах, тайлагнах үүрэгтэй субъект, нэгжүүд багтдаг бол

хамгаалалтын 3 дахь шатанд эрсдэлийн удирдлагад бие даасан үнэлэлт дүгнэлт өгөх дотоод аудит болон бусад хараат бус аудитууд ордог.

Төв банкуудын ашигладаг нэр хүндийн эрсдэлийн удирдлагын өөр нэг арга хэмжээ нь гол оролцогч талуудад чиглэгддэг. Жишээлбэл, Английн төв банкны хувьд тус улсын Парламентад ирсэн олон тооны хүсэлтийг бүртгэж, хянадаг. Канадын төв банк болон бусад олон төв банкууд иргэдийн саналыг хянах зорилгоор тогтмол санал асуулга явуулдаг. Английн төв банк болон Канадын төв банк хэвлэл мэдээллээс бусад салбарын оролцогчидтой уялдаа холбоогоо сайжруулах зорилгоор оролцогч талуудын бүлгийг байгуулсан байх жишээтэй.

Ярилцсанд баярлалаа.

МОНГОЛБАНК 11.2 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны эхний 9 сард 11.2 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 14.3 тонн үнэт металл худалдан авснаас 3.1 тонноор бага буюу 22%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 9 дүгээр сард 1.4 тонн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 31.4 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 104 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.1 тонн үнэт металл худалдан авч байснаас 694 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 9 дүгээр сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 129,726.23 төгрөг байлаа.

Алт худалдан авалтын сарын мэдээ



График 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны сарын мэдээ (кг)




График 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)

Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)





График 3. 2019 оны 9 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2019/09/30-ны хооронд 1,466.9 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1225 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТЭД 313 ТЭРБУМ ТӨГРӨГ ОЛГООД БАЙНА

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны эхний 9 сарын байдлаар нийт 313 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4,447 иргэнд олгоод байна. Үүнээс 2019 оны 9 дүгээр сард Монголбанкны эх үүсвэрээс 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 243 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 130 иргэнд, банкууд өөрийн эх үүсвэрээс нийт 8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 111 иргэнд олголоо.



ХУДАЛДААНЫ ДАЙН БА АМ.ДОЛЛАРЫН ХАНШИЙН ТӨЛӨВ

Өнгөрсөн зууны сүүлчээр даяаршил гэдэг үг ид модонд орж, улс орнууд бүгд өөр хоорондоо хамтарч ажиллахыг уриалж байсан. 2008 оны хямрал хүртэлх 50 гаруй жилийн хугацаанд олон улсын хамтын ажиллагаа, олон талт худалдаа урд хожид байгаагүйгээр цэцэглэн хөгжиж байв. Гэтэл санхүүгийн хямралаас хойш итгэлцэл суларч, улмаар даяаршлын ард асуултын тэмдэг дагах болов. Ялангуяа Дэлхийн худалдааны байгууллагыг буруутгах, шударга бус ажиллаж байгаа тухай шүүмжлэх болжээ. Үүний нэг тод жишээ бол Доналд Трампын хурц үгнүүд бөгөөд улмаар түүний удирдлага доор АНУ нь БНХАУ-ын эсрэг тарифаа чангалж, худалдааны дайныг эхлүүлээд байна. Өдгөө худалдааны дайн нь хоёрхон улсыг хамарсан асуудал биш, дэлхий нийтийн эдийн засагт нөлөөлөх хэмжээнд хүрээд байна. Цаашлаад худалдааны дайн, протекционист бодлого нь валютын ханшийн өрсөлдөөн болж хувирлаа. Иймд энэхүү нийтлэлд худалдааны дайн нь дэлхийн тэргүүлэх валютууд, тэр дундаа ам.долларын ханшинд хэрхэн нөлөөлж байгааг авч үзэх болно.

Өрсөлдөх чадвар ба тарифын дайн

Худалдааны асуудал, протекционист бодлогын үндэс суурь нь улс орнуудын өрсөлдөх чадварын асуудал юм. Аливаа улс орон худалдаа хийхдээ ашигтай байхыг эрмэлздэг. Энд олон улсын худалдаанаас гадна хоёр улсын хоорондын худалдааг хамруулж ойлгох ёстой. Нэг улс нь худалдааны алдагдалтай байхад нөгөө нь ашигтай байх нь зүйн хэрэг юм. АНУ-ын БНХАУ-д дургүйцэж тарифаа нэмэгдүүлэх болсон гол шалтгааны нэг нь худалдааны алдагдал юм. Экспортлогч орны статусаа хадгалахын тулд тухайн улс өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийг

эрмэлздэг. Гэтэл үүнд заналхийлдэг зүйл нь валютын ханш.

БНСУ болон АНУ яг ижилхэн технологийн бүтээгдэхүүн, жишээлбэл шинэ гар утас гарган зарж байхад хүмүүс аль хямдыг нь авахыг эрмэлзэх нь тодорхой. Өөрөөр хэлбэл, вонын ханш сулрах үед Samsung-ийн утасны үнэ хямд болж, хүмүүс iPhone-оос илүү худалдаж авах хандлагатай. Тийм ч учраас АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин ам.долларын ханш сулрах нь манайд ашигтай гэж хэлсэн.

АНУ-ын хувьд ам.долларыг бусад валютын эсрэг зохистой ханшийн түвшинд буюу харьцангуй сул байхыг илүүд үздэг. Гэтэл БНХАУ нь ажиллах хүчний хувьд ч тэр, юанийн ханшийн хувьд ч тэр тогтмол давуу талыг бий болгож иржээ. Цаашлаад оюуны өмчийн асуудал нь гал дээр тос нэмж хоёр улсын харилцааг тодорхойгүй байдалд оруулсан. АНУ нь дэлхийн хамгийн том эдийн засаг бөгөөд олон бүтээгдэхүүн экспортолж, дэлхийд тэргүүлж байгаа ч БНХАУ-тай хийж байгаа худалдаандаа алдагдал хүлээж ирсэн.

АНУ-ын бодлогын хүү ба юанийн ханш

Ерөнхийлөгч Трамп Холбооны нөөцийн банкны хараат бус байдалд ноцтойгоор халдаж, тэргүүн Жером Повеллийг бодлогын хүүгээ хангалттай бууруулахгүй байна гэж твиттерээр тогтмол шүүмжилж байгаагийн гол зорилго нь худалдааны дайнд давуу тал бий болгоход оршино. Бодлогын хүүг бууруулах үед мөнгөний үзүүлэлт, банк хоорондын хүүгийн түвшин буурч, улмаар ам.долларын ханшийг сулгах нөлөөтэй. Ам.долларын ханш суларвал АНУ-аас гаргаж байгаа автомашин, гар утас, технологи, хүнс

газар тариалангийн бүтээгдэхүүнүүдийн үнэ буурч улмаар өрсөлдөгч улсуудаасаа илүү их экспорт хийх юм. Холбооны нөөцийн банк нь тухайлсан бус хувьсах хүүг ашигладаг бөгөөд 2018 оны 12-р сар хүртэл 2.25%-2.50% хооронд тогтож байсан хүүг 2019 онд 2 удаа бууруулан 1.75%-2.00% хүргэв.

Холбооны нөөцийн банкны бодлогын хүүний өөрчлөлт



Эх сурвалж: Trading economics

Нөгөө талаар БНХАУ юанийн ханшийг бага байлгахын тулд мөнгөний захад манипуляци хийж байна гэж АНУ-ын зүгээс үзэж байгаа. Угаас зохиомлоор ханшид нөлөөлж, худалдааны давуу тал бий болгох нь шударга бус бөгөөд ОУВС-ийн тайланд БНХАУ манипуляци хийгээгүй гэж баталжээ. Уг тайланд Хятадын 2018 оны эцсийн байдлаарх гадаад секторын үзүүлэлтийг авч үзэхэд тус улсын урсгал дансны ашиг жилийн дотор ДНБ-ний 1.0%-тай дүйцэх хэмжээгээр буурч 0.4% хүрсэн байна. Удирдлагатай хөвөгч ханшийн дэглэмтэй тус улсын Төв банк Хятадын ардын банкнаас валютын ханшийн өөрчлөлтийг өдөрт $\pm 2\%$ байхыг зөвшөөрдөг бөгөөд энэ хүрээнд хязгаарлалттай интервенцийн хийдэг. Тэгвэл ОУВС-ийн тайланд юанийн ханш нь валютын сагсан дахь бусад орны мөнгөн тэмдэгтүүдийн эсрэг өмнөх жилээс дунджаар 2.5% буурсныг онцолжээ. Иймд ренминби буюу юанийн ханшийн түвшин дунд хугацаанд эдийн засгийн сууриа дагаж байгаа ба илүү, эсвэл дутуу үнэлэгдсэн зүйл байхгүй гэж дүгнэжээ. Энэ оны 9-р сарын байдлаар 1 ам.доллар нь 7.1 юань орчим хэлбэлзэж байсан бол өмнөх оны мөн үед 6.8 орчим хэлбэлзэж байжээ. Өөрөөр хэлбэл, жилийн дотор юанийн ханш энэ хэмжээгээр суларч, Хятадын экспортын бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөх чадвар нэмэгджээ.

Ам.долларын ханшийн өөрчлөлт

Хоёр орны худалдааны эргэлт 640 тэрбум ам.доллар буюу Монгол Улсын эдийн засгаас 60 дахин их бөгөөд 2018 оноос хойш өрнөж байгаа тарифын дайн нь ам.долларын ханшид дангаараа болон бусад хүчин зүйлстэй хавсран нөлөөлж байгаа. Энд тодруулж хэлэхэд аливаа валютын ханшийн өөрчлөлтийг гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах буюу бодит үйлчилж буй ханш (REER)-ээр илэрхийлбэл ихээхэн тодорхой дүр зургийг гаргаж ирдэг. Тийм ч учраас энд тухайлсан валют гэхээс илүү REER ханшийн өөрчлөлтийг тайлбарлах нь зүйтэй болов уу.

Өнгөрсөн оны 7-р сард АНУ нь БНХАУ-ын 34 тэрбум ам.долларын бүтээгдэхүүнд 25 хувийн тариф ногдуулж эхэлснээр худалдааны дайны анхны гал авалцсан. Тухайн үед 2005 оны суурь жилээр тооцсон ам.долларын REER ханшийн индекс 102 орчим хэлбэлзэж байсан бол өдгөө энэ нь 106 руу дөхөж ирээд байна. Өөрөөр хэлбэл 2018 оны 7-р сараас 2019 оны 9-р сарын хооронд ам.долларын ханш бусад валютын эсрэг дунджаар 3.5 орчим хувь чангарчээ.

Ам.долларын ханш өсөхөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ чангаруулсан, 2018 онд эдийн засаг 2.6% өссөн зэрэг нь ам.долларт итгэх итгэлийг нэмэгдүүлжээ. Гэхдээ дэлхийн эдийн засагт сүүдэр тусаж эхэллээ. АНУ-ын засгийн газрын үнэт цаасны өгөөжийн муруй урт хугацаанд өсөх хэлбэртэй байдаг нь эсрэгээрээ буурсан мөн ирээдүйн итгэлийг харуулдаг индексүүд сөрөг дүр зургийг бий болгож байгаа. ХНБ бодлогын хүүгээ буруулж эхэлсэн зэрэг нь ам.долларын ханшийг цаашид өсөхгүй гэсэн дохиог өгч байна.

Эх сурвалж: <https://www.imf.org/-/media/Files/Publications/CR/2019/1CHNEA2019003.ashx>
<https://www.fxcm.com/uk/insights/u-s-china-trade-war-impact-on-usd/>

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ЦАГААН ДАРА ЭХ


XVII зуун
Өндөр Гэгээн Занабазарын урлал
Алт шармал, хүрэл цутгамал
72 x 44 см
Дүрслэх урлагийн музей.
Хосгүй үнэт дурсгал

Занабазарын Цагаан дара эх
бурхан нь залуухан үзэсгэлэн
төгөлдөр, охидын сонгодог дүрийг
ухаалаг тэнүүн магнай, саран
хөмсөг, торгомсог нимгэн нөмрөг,
өмсгөлийн цаанаас нэвт гэрэлтэх
гуа сайхан бие, галбир, бэлхүүсийг
гайхамшигтай дүрсэлсэн уран
баримлын сонгодог бүтээл билээ.



**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 27/IX ӨДРИЙН БАЙДЛААР)**

tth



Б.ДАВААДАЛАЙ: ТӨВ БАНК НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГАРАЛТАЙ ИНФЛЯЦИД ШУУД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ НЬ ЗОХИСГҮЙ

Дэлхийн банкны эдийн засагч
Б.Даваадалайтай ярилцлаа.



Мөнгөний бодлогын хороо удахгүй энэ оны гуравдугаар мэдэгдлээ хийх гэж байна. Инфляци энэ оны 8 дугаар сарын эцэст 8.9 хувьд хүрсний дийлэнх нь нийлүүлэлтийн гаралтай инфляци байгааг статистикийн хорооноос зарласан. Төв банк үүнд мөнгөний бодлогоор ямар хариу өгөх бол?

Инфляци 2016 оны сүүлээс хойш инфляци ерөнхийдөө төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Энэ оны 8 дугаар сарын сүүлийн байдлаар улсын инфляци 8.9 хувь, Улаанбаатар хотынх 10 гаруй хувьтай гарсан байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байна. Юун түрүүнд сүүлийн саруудад нийлүүлэлтийн гаралтай инфляцийн өсөлт нийт

инфляцийн багагүй хэсгийг тайлбарлах болсон. Тухайлбал, махны үнэ, хатуу түлш, шатахууны үнэ, бусад төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр нөлөөтэй байна. Нөгөө талдаа эдийн засгийн идэвхжил, хувь хүмүүсийн худалдан авах чадвараас хамааралтай хөдөлж байдаг суурь инфляцийн түвшин ч бас өсч байгаа. Гэхдээ хараахан аюул тарих түвшинд хүрээгүй, төв банкны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Наймдугаар сарын үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өнгөрсөн оны 8 дугаар сард сарын өсөлт нь нэлээд бага байсан. Тухайн үед улирлын шинж чанартайгаар хүнсний ногоо болон махны үнэ буурч байсан. Тэгэхээр нэгдүгээрт, өнгөрсөн оны 8 дугаар сард инфляци сарын

дүнгээрээ нэлээд бага байсан нь энэ оны 8 дугаар сард инфляци өсөхөд суурь үеийн нөлөө үзүүлсэн гэж харж байна. Нөгөө талдаа энэ оны тухайд махнаас бусад бараа, бүтээгдэхүүний үнэ бага зэрэг өссөн байгаа. Шинэ хичээлийн жил эхлэхтэй холбоотойгоор их, дээд сургуулиудын төлбөр, оюутны дотуур байр, дунд сургуулиудын үнэ өссөн. Их, дээд сургуулиудын сургалтын төлбөр 12 орчим хувиар, дотуур байрны үнэ 30 орчим хувь, дунд сургуулиудынх 7 орчим хувиар өссөн нь инфляцийн өсөлтөд нөлөөлсөн. Тэгэхээр нийлүүлэлтийн гаралтай инфляцийг төв банк анхааралтай ажиглаж байгаа байх. Гэхдээ нийлүүлэлтийн гаралтай, түр зуурын шинжтэй үнийн өсөлтөд төв банк шууд бодлогын хариу үйлдэл үзүүлэх нь бусад үзүүлэлтүүдэд сөрөг

нөлөөтэй, үр дүн муутай байдаг нь олон судалгаагаар нотлогдсон.

Тэгэхээр инфляцийн өсөлтийн ихэнх хувийг нийлүүлэлтийн шинжтэй бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлж байгаа учраас төв банк энэ удаад бодлогын хүүг хэвээр хадгалах нь гэж хүлээж болох уу?

Гэхдээ инфляцийн дарамт өндөр байгааг анхаарах шаардлагатай. Ирэх саруудад инфляцийн эрэлтийн гаралтай дарамт нэмэгдэх шалтгаан олон байна. Төсөв нэмэгдсэн, цалин өссөн. Тэгэхээр цалингаар дамжуулаад хүмүүсийн бодит орлого, худалдан авах чадвар өссөн. Эхний хагас жилийн байдлаар өрхийн бодит орлого 10 орчим хувиар нэмэгдсэн. Энэ бол худалдан авах чадвараар дамжаад инфляцид дарамт учруулах хүчин зүйл болно. Үүнээс гадна төсвийн хөрөнгийн зардал энэ онд өмнөх оноос нэлээд өндөр дүнтэй батлагдсан. Эхний 8 сарын гүйцэтгэлийг харвал хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад бараг 70 орчим хувиар өссөн байна. Ирэх саруудад хөрөнгө оруулалтын зардлууд мөн л нэмэгдэнэ. Тэгэхээр төсвөөс хамааралтайгаар инфляцийн дарамт ирэхийг үгүйсгэхгүй. Тэгвэл үүний нөгөө талд банкны салбараас ирэх зээлийн өсөлтөөр дамжсан инфляцийн дарамт харьцангуй бага байх болов уу. Төв банкнаас хэрэгжүүлж буй макро зохистой бодлогын үр дүнд зээлийн өсөлтийг нэлээд хязгаарлаад байна. Наймдугаар сарын эцсийн байдлаар иргэдийн зээлийн өсөлт өнгөрсөн оны эцэст 36 орчим хувьтай байсан бол одоо 20 орчим хувь руу буурсан

байна. Аж ахуйн нэгжүүдэд олгож байгаа зээл өнгөрсөн оны эцэст 17 орчим хувьтай байсан бол одоо 12 орчим хувь болсон байна. Тэгэхээр банкны салбарын зээлийн өсөлтөөс шалтгаалсан инфляцийн дарамт бага байх боломжтой. Энэ мэт олон хүчин зүйлийг анхаарч үзсэнээр төв банк бодлогын шийдвэрээ гаргах болов уу. Гэхдээ эрсдэл байгааг бас хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хамгийн сүүлийн жишээ газрын тосны үнэ өсөөд эхэллээ. Энэ нь манай голлох импортын бүтээгдэхүүн болох шатахууны үнэд нөлөөлөх байх.

Дотоод хүчин зүйлс ийм байгаа бол гадаад хүчин зүйлсийн тухайд та хэрхэн харж, дүгнэж байна вэ. Хамгийн сүүлд жишээ нь газрын тосны үнэ өслөө. Үүнтэй холбоотойгоор дэлхийн ихэнх улс орнууд бодлогын хүүгээ бууруулах арга хэмжээ авч байгаа нь хөрөнгийн гадагшлах урсгалыг нэмэгдүүлж, ханшийн дарамтыг бий болгодог шүү дээ?

Шатахууны үнэ дарамт үзүүлэх боломжтой. Дээрээс нь ихэнх төв банкууд эдийн засгийн удаашралтыг тэтгэх зорилгоор бодлогын хүүгээ бууруулж байна. Үүнийг дагаад санхүүгийн урсгалтай холбоотой инфляцид бага зэргийн нөлөө үзүүлэх боломжтой. Гэхдээ хэр их хэмжээний хөрөнгийн урсгал хөгжиж байгаа орнуудаас хөгжингүй орнууд руу шилжих вэ гэдгээс хамаарах байх. Үүн дээр шууд, өндөр нөлөөлөл манай орны хувьд гарахгүй болов уу. Манай улсын хувьд хамгийн гол нөлөөлдөг зүйл нь нэгдүгээрт инфляци, хоёрдугаарт хүнсний бүтээгдэхүүн.

Ихэнх хүнсний бүтээгдэхүүнээ импортоор авч байгаа. Тийм учраас импортын барааны үнийг анхаарах шаардлагатай. Дээрээс нь ханш нэлээд нөлөөлдөг. Сүүлийн саруудад импортын өсөлт буурч байгаа. Наймдугаар сарын эцэст 7 орчим хувьтай байгаа. Өмнөх жилүүдтэй харьцуулахад импортын өсөлт огцом буурсан. Тийм учраас импортоор дамжиж орж ирэх нөлөөлөл бага байхаар байна. Дээрээс нь ханшийн дарамтын тухайд сүүлийн сард төгрөг бага зэрэг чангарч байна. Олон улсын байгууллагаас санхүүжилтээ өгөөд эхэлсэн. Он дуустал 700 орчим сая ам.долларын нэмэлт орлого орж ирэхээр байна. Тэгэхээр ханшаар дамжиж орж ирэх инфляцийн дарамт харьцангуй бага байх болов уу.

Хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын шийдвэр хэрэгжиж эхлээд багагүй хугацаа өнгөрлөө. Үр дүнг та хэрхэн харж байна вэ?

Нэгдүгээрт, энэ нь төв банкнаас зайлшгүй авч хэрэгжүүлэх ёстой байсан арга хэмжээ юм. Яагаад гэвэл 2018 онд импортын өсөлт маш ихээр нэмэгдсэн. Эдийн засаг идэвхжихийн хэрээр импорт дагаад өсдөг. Энэ нь манайх шиг экспортын орлого нь цөөн хэдэн бараа, бүтээгдэхүүнээс хамааралтай улсын хувьд ханш дээр ирэх дарамтыг нэмэгдүүлж байдаг. Үүний эсрэг, валютын нөцийг хамгаалж, ханшийн дарамтыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн зайлшгүй арга хэмжээ байсан. Хэрэгжилт нь энэ оны эхнээс эхэлсэн. Шийдвэр өнгөрсөн оны дундуур гарсан. Бидний



Энэ оны 8 дугаар сарын сүүлийн байдлаар улсын инфляци 8.9 хувь, Улаанбаатар хотынх 10 гаруй хувьтай гарсан байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байна. Юун түрүүнд сүүлийн саруудад нийлүүлэлтийн гаралтай инфляцийн өсөлт нийт инфляцийн багагүй хэсгийг тайлбарлах болсон. Тухайлбал, махны үнэ, хатуу түлш, шатахууны үнэ, бусад төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт өндөр нөлөөтэй байна. Нөгөө талдаа эдийн засгийн идэвхжил, хувь хүмүүсийн худалдан авах чадвараас хамааралтай хөдөлж байдаг суурь инфляцийн түвшин ч бас өсч байгаа.



зүгээс шийдвэрийг гаргамагцаа хэрэгжүүлж эхэлсэн бол илүү өндөр үр дүнтэй байх байсан гэж харж байгаа. Яагаад гэвэл оны эцэст хэрэглээний зээл нэлээд хэмжээгээр нэмэгдсэн шүү дээ. Ямартай ч шийдвэр хэрэгжиж эхэлснээрээ тодорхой үр дүн авчирч байгаа. Ялангуяа хэрэглээний импорт нэлээд буурсан. Хэрэглээний зээлийг хумих замаар хэрэглээний импортыг бууруулж, ханшийн дарамтыг бууруулж, гадаад тэнцвэртэй байдлыг хангах тал дээр үр дүнгээ өгсөн гэж харж байгаа. Бидний зүгээс цаашдаа зөвхөн хэрэглээний зээл дээр бодлогын арга хэмжээ аваад, бусад зээлээ орхигдуулах уу, үгүй юу гэдэг асуудлыг тавьж байгаа. Чанаргүй зээлийг харвал хэрэглээний зээлийн хувьд харьцангуй бага байдаг. Ихэнх чанаргүй зээлийг бүрдүүлж байгаа зүйл нь хувийн хэвшил, аж ахуйн нэгжид олгосон зээл. Тэгэхээр банкны салбар, макро тогтвортой байдлыг хангах үүднээс авч үзвэл зөвхөн хэрэглээний зээл гэлтгүй, аж ахуйн нэгж, хувийн секторт олгосон зээлүүдэд тодорхой хэмжээгээр эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах талаар судлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Төгсгөлд нь танаас гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар асууя. Эхний 8 сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 44 сая ам.доллараар буурсан үзүүлэлт болсон байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтыг задлаад үзвэл 10 төгрөг тутмын 9 нь мега төслүүд рүү орсон байгаа юм. Тэгэхээр гадаадын шууд хөрөнгө

оруулалтын энэ их төвлөрлийг задлах нь

Энэ мэдээж эдийн засгийн төрөлжилттэй холбоотой асуудал. Өнгөрсөн жилүүдийн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг авч үзвэл 70 орчим хувь нь уул уурхайд орж байгаа. 2000-аад оноос хойш уул уурхайн салбар Монголын эдийн засгийн тэргүүлэх салбар болсон учраас ийшээ хөрөнгө оруулалт орох нь зайлшгүй. Гэхдээ хөрөнгө оруулалтыг илүү төрөлжүүлж, бусад салбарт хөрөнгө оруулалт татах вэ гэдэг нь чухал асуудал. Үүн дээр хууль эрх зүй гэх зэрэг нэлээд олон асуудлыг ярьж болно. Бусад салбарын хөрөнгө оруулалтыг яаж түлхүү дэмжих вэ гэдэг дээр Засгийн газрын бодлогоос хамаарна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд ажиглагдаж байгаа зүйл юу вэ гэхээр махны экспорт нэмэгдэж байна. Уул уурхайгаас гадна хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг татах бүрэн боломжтой гэж хардаг. Тэгэхээр энэ салбарт хөрөнгө оруулалтыг татах тал дээр яаж хамтран ажиллах, бизнес эрхлэлтийн ерөнхий орчноо яаж сайжруулах вэ гэх зэрэг асуудал бий. Түүнчлэн аялал жуулчлал зэрэг бусад салбарт хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэдэг дээр Засгийн газар үр дүнтэй ажиллах нь зөв юм.

АРГУН ХААНЫ

Монгол зоос

1284-1291 он

Жин: 2.3 гр

голч: 2.1 см

НҮҮР ТАЛ: "Хааны нэрээр
Аргун дэлдүүлсэн" гэж монгол
бичгээр бичсэн.

АР ТАЛ: "Аллахаас өөр бурхан
үгүй. Мухаммед бол Аллахын
элч" гэж араб бичигтэй.




ЭДИЙН ЗАСГИЙН СЭРГЭЛТ, ТҮҮНИЙ ӨРХИЙН АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Н.БАЯРТСАЙХАН (Монголбанкны Ерөнхийлөгч, Доктор, Профессор)

Монгол Улсын эдийн засаг тогтвортой өсч байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 онд сүүлийн 4 жилийн өндөр түвшин буюу 6.9 хувьд хүрсэн бол 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.6 хувьд хүрч эрчимжээд байна. 2019 оны 1 дүгээр улирлын өсөлтөд уул уурхай, аж үйлдвэр, барилгын салбарын оруулсан хувь нэмэр (3.8 хувь) өмнөх оны мөн үеэс эрс нэмэгдэв. Үйлчилгээ, худалдааны салбарууд эдийн засгийн

өсөлтийн 3.9 нэгж хувийг бүрдүүлэв. Харин эрэлт талаас өрхийн эцсийн хэрэглээ 2.7 нэгж хувь, үндсэн хөрөнгийн хуримтлал 11.8 нэгж хувь болон цэвэр экспорт –6.6 нэгж хувийг тус тус бүрдүүлээ. Хэдийгээр дотоодын эдийн засаг 2019 оны эхний улирлын байдлаар өндөр өсөлттэй гарсан ч, гадаад зах зээл дээрх тодорхой бус байдлын эрсдэлтэй байсаар байна.

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, түүнд оруулж буй хувь салбаруудаар



Эх сурвалж: УСХ


АНУ-Хятад улсын худалдааны маргаан дэлхийн түүхий эдийн зах зээлд тодорхой бус байдлыг үүсгээд байна. Уг маргаан шийдэгдэхгүй цаашид үргэлжилэх нь Хятадын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж,

тус улсын зэсийн баяжмал болон нүүрсний импортыг бууруулах магадлалтай юм. Энэ нь манай орны түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, эдийн засгийн өсөлтийг саармагжуулж болзошгүй.

Эдийн засгийн өсөлт, сэргэлтийг даган өрхийн орлого болон дундаж цалин өсч байна. Иргэдийн орлогын үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл улсын дундаж цалин¹ 2019 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өсч, 1157.9 мянган төгрөг, улсын медиан цалин 4.1 хувиар нэмэгдэж, 734.7 мянган төгрөг болоод байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбаруудын хувьд дундаж цалин 729.9-2,825.1 мянган төгрөгийн хооронд байна. Тодруулбал, боловсрол (22.7 хувь), эрүүл мэнд (21.4 хувь), барилга (21.3 хувь), төрийн захиргаа (21.1 хувь), уул уурхай (15.7 хувь), ХАА (12.9 хувь), худалдаа (12.6 хувь), боловсруулах (10.8 хувь) салбаруудад ажиллагчдын дундаж цалин өсөлттэй байна.

Зураг 2. Цалингийн өсөлт, эдийн засгийн салбарын ангиллаар



Эх сурвалж: УСХ

Гадаад улсад аялах Монгол иргэдийн тоо болон Монгол Улсад аялах жуулчдын тоо өссөөр байна. Монгол Улсаас гадаад улсад аялах иргэд, жуулчдын тоо болон нөгөө талаасаа гадаадын жуулчид Монгол Улсад аялах нь өссөөр байна. Тодруулбал, 2019 оны эхний 5 сарын байдлаар гадаад улсад аялагчдын тоо 106,793 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 хувиар нэмэгджээ. Цаашид жуулчдын орох, гарах урсгал өсөх хандлагатай байна.

Иргэдийн зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас өндөр байна. Иргэдийн зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас нэмэгдэж байна. Ялангуяа, 2018 оны 4 дүгээр сараас хойш зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас өндөр байна. Энэ оны эхний 4 сарын байдлаар иргэдийн зээлийн эргэн төлөлт өмнөх оны мөн үеэс 19 хувиар илүү байв. Зээлийн эргэн төлөлт өмнөх онуудаас өсч байгаа нь иргэдийн орлого нэмэгдсэн, 2018 онд зээл олголт өссөн зэрэгтэй холбоотой байна.

¹ Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А-203 дугаар тушаалаар “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн ил тод байдлын журам”-ыг шинэчлэн баталсан. Энэ журмын зорилго нь банкны хүү, тэр дундаа, зээлийн хүү бодоход баримтлах зарчмыг тодорхойлох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийг банкны харилцагчдад ил тод байлгах, улмаар хадгаламж эзэмшигч, харилцагчад /ө.х зээлдэгч/-ын эрх ашгийг хамгаалах юм.

Зээлийн хүү гэж зээлд төлж буй үнэ бөгөөд зээл ашиглагчийн хувьд зардлыг хэлнэ. Харилцагч банкнаас зээл авсан тохиолдолд зээлийн хүүг тус журмын 1 дүгээр хавсралтаар баталсан “Мөнгө хадгаламж, зээлийн хүү болон үнэт цаасны өгөөж, хямдруулалтын хувь хэмжээг бодох ерөнхий аргачлал”-ын дагуу тооцдог.

Харилцагч банкнаас орон сууцны зээл, ипотекийн зээл, орон сууцны зээл гэх зэрэг хэсэгчлэн төлөх нөхцөл бүхий зээлийг авахдаа сар бүрийн нийт төлбөр тогтмол эсвэл сар бүрийн үндсэн төлбөр тогтмол гэсэн хоёр хувилбараас сонголт хийх боломжтой. Сарын нийт төлбөр тогтмол үед зээлдэгчийн сар бүрийн төлбөр ижил хэмжээтэй боловч банкинд нийт хугацааны туршид төлөх хүүгийн зардал арай өндөр байдаг. Харин үндсэн төлбөр тогтмол үед зээлдэгчийн эхний саруудын төлбөр өндөр байх бөгөөд нийт хүүгийн зардал өмнөх тохиолдлоос арай бага байдаг. Учир нь хүүнд хэдэн төгрөг төлөхөөс хамаарахгүйгээр үндсэн зээлээс тогтмол өндөр дүнгээр хасагддаг.

“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн ил тод байдлын журам”-ын 5.4-д “Иргэнд

олгосон зээлийн хүүг олгох зээлийн дүнгээс суутгах эсхүл ирээдүйд хуримтлуулах хүүг зээл олгохоос өмнө урьдчилж төлүүлэх, энэ зорилгоор эх үүсвэр дансанд байршуулахыг хориглоно” гэж заасан байна.

Иргэдийн дунд “банк зээлийн хүүг урьдчилан суутгаж авдаг” талаар эргэлзээ, үйл ойлголцол байдаг. Банк харилцагчаас зээлийн хүүг урьдчилж суутгаж авдаг эсэхийг тодруулах үүднээс тэтгэврийн зээлийн бүтээгдэхүүнээр жишээ авч тайлбарлая. Тэтгэврийн зээл нь ирээдүйд авах тэтгэврийн орлогоороо зээлийн эргэн төлөлтийг бүрдүүлэх нөхцөлтэй санхүүгийн бүтээгдэхүүн бөгөөд зээлдэгч тэтгэврийн орлогын зарим хэсгээр ашигласан зээлийн хүүг төлж, үлдэх хэсгээр үндсэн төлбөрийг төлж бууруулдаг.

Иргэн А нь сар бүр 250,000 төгрөгийн тэтгэвэр авдаг, түүнд өөр тогтмол орлого байхгүй. Иргэн А-д 3,000,000 төгрөгийн санхүүгийн хэрэгцээ гарчээ, тэр хувьдаа тооцоолол хийгээд 12 сарын тэтгэврээ барьцаалбал 3,000,000 төгрөгийн зээл авна гэж боджээ. Ингээд БББ банкинд 3,000,000 төгрөгийн зээлийг жилийн 18 хувийн хүүтэй, эргэн төлөлтийг Нийгмийн даатгалын сангаас сар бүрийн эхний өдөр тэтгэврийн санхүүжилт банкинд орж ирэхэд шууд төлөх хүсэлт гаргажээ.

Хэдийгээр тус иргэний 12 сарын нийт тэтгэврийн орлого нь 3,000,000 төгрөг болж байгаа хэдий ч үндсэн зээл болох 3,000,000 төгрөгийг ашигласны төлөө төлөх хүүг төлөхийн тулд 12 сараас урт хугацааны тэтгэврийн орлогоо барьцаалах шаардлага үүснэ. Энэ зээлтэй холбогдох эргэн төлөлтийн хуваарь буюу зээл ашиглах хоног, төлөх хүү, үндсэн төлбөр, зээлийн өрийн үлдэгдлийг доор хүснэгтэд харууллаа.

Огноо	Сар	Үлдэгдэл	Хүү	Зээл	Төлбөр	Хүү тооцсон хоног
2018-09-01	0	3,000,000				
2018-10-01	1	2,769,097	44,384	230,903	275,287	30
2018-11-01	2	2,536,143	42,333	232,954	275,287	31
2018-12-01	3	2,298,377	37,521	237,766	275,287	30
2019-01-01	4	2,058,226	35,137	240,150	275,287	31
2019-02-01	5	1,814,405	31,465	243,822	275,287	31
2019-03-01	6	1,564,172	25,054	250,233	275,287	28
2019-04-01	7	1,312,797	23,913	251,374	275,287	31
2019-05-01	8	1,056,932	19,422	255,865	275,287	30
2019-06-01	9	797,803	16,158	259,129	275,287	31
2019-07-01	10	534,320	11,803	263,484	275,287	30
2019-08-01	11	267,201	8,169	267,118	275,287	31
2019-09-01	12	0	4,085	267,201	271,286	31
Нийт			299,444	3,000,000	3,299,444	365

Хүснэгтээс харахад иргэн А нь 3,000,000 төгрөгийн зээлийг 1 жил ашигласны төлөө банкинд 3,299,444 (үндсэн зээл+хүү) төгрөгийг жилийн туршид эргүүлж төлөхөөр байна. Гэхдээ иргэн А нь 12 сарын хугацаанд нийт 3,000,000 төгрөгийн тэтгэвэр авна, түүнд хүүгийн төлбөрт төлөх 299,444 төгрөгийн нэмэлт орлого байхгүй гэвэл банк иргэн А-гийн санхүүгийн чадварт нийцүүлэн тооцоолол хийх шаардлага гарна, өөрөөр

Энэхүү тооцоог дараах зарчмын дагуу хийнэ.

$$\text{Олгож болох зээл} = \text{Сар бүр тогтмол төлөх дүн} * \frac{(1+\text{хүү})^{\text{Эргэн төлөлт хийх тоо}} - 1}{\text{хүү} * (1+\text{хүү})^{\text{Эргэн төлөлт хийх тоо}}} = 2,726,079.7$$

$$250,000 \frac{(1+1.5\%)^{12} - 1}{1.5\% * (1+1.5\%)^{12}} =$$

Өөрөөр хэлбэл тус иргэнд 2,726,079.7 төгрөгийн зээлийг олгосон нөхцөлд ирэх 12 сарын хугацааны нийт хүү, үндсэн төлбөрийн нийлбэр 3,000,000 төгрөг

хэлбэл иргэн А-гийн эргэн төлөлтийн чадвар нийтдээ 3,000,000 төгрөгөөр хязгаарлагдах тул анхнаасаа хэдэн төгрөгийн зээлийг олгосон тохиолдолд ирэх 12 сарын хугацаанд зээлийн үндсэн төлбөр, хүүгийн нийт төлбөр бүгд 3,000,000 сая төгрөгтэй тэнцэх тооцоог банк хийх шаардлагатай болно.

байхаар байна. Иргэн А нь 2,726,079.7 төгрөгийн зээл авах бол эргэн төлөлт нь дараах байдалтай байна.

Огноо	Сар	Үлдэгдэл	Хүү	Зээл	Төлбөр	Хүү тооцсон хоног
2018-09-01	0	2,726,079				
2018-10-01	1	2,516,259	40,331	209,820	250,151	30
2018-11-01	2	2,304,576	38,468	211,683	250,151	31
2018-12-01	3	2,088,520	34,095	216,056	250,151	30
2019-01-01	4	1,870,298	31,929	218,222	250,151	31
2019-02-01	5	1,648,739	28,592	221,559	250,151	31
2019-03-01	6	1,421,354	22,766	227,385	250,151	28
2019-04-01	7	1,192,932	21,729	228,422	250,151	31
2019-05-01	8	960,430	17,649	232,502	250,151	30
2019-06-01	9	724,962	14,683	235,468	250,151	31
2019-07-01	10	485,536	10,725	239,426	250,151	30
2019-08-01	11	242,808	7,423	242,728	250,151	31
2019-09-01	12	0	3,712	242,808	246,520	31
НИЙТ			272,102	2,726,079	2,998,181	365

Өөрөөр хэлбэл, банкны зээл хүүтэй учраас ирээдүйн орох орлого буюу тэтгэврийг 100 хувь бүтэн зээлдэх боломжгүй юм. Цалингийн болон бусад хэрэглээний зээлийн хувьд нийт цалин болон орлогын тодорхой хувьтай (70-80 хувь г.м) тэнцэх хэмжээний зээл олгодог.

Иймд дээр тайлбарласан тэтгэврийн зээлийн хувьд банк зээлийн хүүг урьдчилж суутгаж авсан гэж үзэхгүй.

Харин дараах тохиолдолд банк зээлийн хүүг иргэн А-гаас урьдчилж суутгасанд тооцно. Тухайлбал, иргэн А нь 3,000,000 төгрөгийн зээлийг 2018 оны 9 дүгээр сарын 01-нд авсан, зээлийн эхний төлөлт болох 250,151

төгрөгийг 10 дугаар сарын 01-нд буюу зээлийг 30 хоног ашигласны дараа төлөх ёстой (250,151 төгрөгийн 40,331 төгрөг нь хүүнд, 209,820 төгрөг нь үндсэн зээлийн төлбөр байна). Банк иргэн А-гаас 10 дугаар сарын 01-нд төлөх хүүгийн төлбөр болох 40,331 төгрөгийг 9 дүгээр сард төлүүлэх бол урьдчилан төлүүлсэнд тооцно.

Банк хүүг урьдчилан суутгасан эсэхийг дээрх аргачлалаар шалгаж болохоос гадна энгийнээр шалгах боломжтой. Ингэхийн тулд зээлийн гэрээн дээр бичсэн зээлийн дүнг өөрийн гар дээр хүлээн авсан мөнгөтэй тулгаж үзнэ. Хэрэв энэ 2 дүн таарч байвал таниас хүүг урьдчилан аваагүй болно.



ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА
Санхүүгийн ЛУЙВАР



Хэрэв та санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болсон бол санаа зовох хэрэггүй. Энэ тухайгаа холбогдох газарт мэдээлэх хэрэгтэй. Ийнхүү мэдээлснээр та өөрийнхөө хохирлыг эргүүлэн олж авах болон бусад хүмүүсийг ижил төрлийн санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд туслана.



“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /Mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081